

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ ЖАНГАРЫН ТУУЛЬ

Уламжлалт эхийг баримтлан
нэмэн засварлаж шүлэглэсэн
Цэндийн Дамдинсүрэн

Улаанбаатар
2008 он

DDC
398.202'517
Ж-249

*Ц.Дамдинсүрэнгийн мэндэлсний
100 жилийн ойд зориулав.*

МОНГОЛ ЖАНГАРЫН ТУУЛЬ

Хэвлэлд бэлтгэсэн: Р. Отгонбаатар
Зураач: С. Мижиддорж

Номын хэмжээ: 70x100/16
Хэвлэлийн хэмжээ: 16.75х.х
Хэвлэсэн тоо: 1500 ширхэг



“Содпресс” ХХК-д хэвлэв.

ISBN 978-99929-54-54-X

9 789992 789992 95454X



Хэвлэлд бэлтгэгчийн хэдэн үг

Монголын эртний уран зохиолыг судалсан академич, шинэ уран зохиолыг үндэслэсэн анхны ардын уран зохиолч Ц.Дамдинсүрэн эртний монгол хэл аялгууг эдүгэечлэн буулгах, өрнө дорны олон хэлээс зохиол бүтээл орчуулах үлгэр жишээг үзүүлсэн билээ.

Их бичгийн хүн Ц.Дамдинсүрэнгийн мэндэлсний 100 жилийн ойд зориулан монголын уран зохиолын гурван их оргил болсон бүтээлийг багшийн боловсруулсан эхийг баримтлан хэвлэж даяар олонд бэлэг болгон барив. Чингэхдээ өмнөх хэвлэлүүдийг нэгдсэн журамд оруулж дэглэхийг хичээллээ. Бүх номын бүлэг тус бүрт буюу арав орчим зургийг эрхэм зураач анд нөхөр С.Мижиддоржоор бүтээлгэв. Мөн хавтас, шил, хүрээ зэргийг өөрийн чадах чинээгээр нэгдмэл болгохыг зорьсон болно. Ийнхүү нэгэн иж цомог гурван эрдэнэ ном бүрийн эцэст багшийн гар бичмэлийн зургаас цөөн хуудас хавсаргалаа.

*Ц.Дамдинсүрэнгийн шавь Р.Отгонбаатар
2008 он*

Монгол улсын төрийн гурван удаагийн шагналт академич, ардын уран зохиолч Цэндийн Дамдинсүрэнгийн мэндэлсний зуун жилийн ой энэ онд болж буй нь монголчууд бидний соёлын амьдралын хувьд нэгэн түүхэн үйл явдал болж байна.

Манай монголчуудын олон үеийнхний туурвисан оюуны баялаг өв санд Цэндийн Дамдинсүрэнгийн үлдээсэн зохиол бүтээл эрхэм суурийг эзэлнэ.

Учир иймээс Монгол улсын Ерөнхий сайдын 2007 оны дугаар захирамжаар батлагдсан Цэндийн Дамдинсүрэнгийн зуун жилийн ойг зохион байгуулах хороо түүний бүтээлийн өв сангаас уншигч олон, өсвөр залуу үеийнхэнд танилцуулах, судлаач нарт хүргэх зорилгоор эдгээр ном зохиолыг хэвлүүлж буй нь энэ ойг тэмдэглэсний чухал дурсгал болон үлдэнэ гэдэгт гүнээ итгэж байна.

Мэргэжлийн байгууллага, эрдэмтэн хүмүүсийн сонголтоор хэд хэдэн бүтээл, холбогдох ном зохиолыг нь түүний мэндэлсний зуун жилийн ойгоор Монгол улсын Засгийн газраас санхүүжүүлж, манай улсын бүх нийтийн болон ерөнхий боловсролын сургуулийн номын санд үнэ төлбөргүй олгохоор шийдвэрлэсэн нь уншигч олныхоо мэдлэгт оруулж буй чухал хөрөнгө оруулалт юм.

Эдгээр ном бүтээл нь Цэндийн Дамдинсүрэнгийн зохиол туурвилиг сонирхон судлагч гадаад, дотоодын уншигч эрдэмтэн хэн бүхний шимтэн үзэх эх хэрэглэхүүн болно хэмээн найдаж итгэнэ.

*Цэндийн Дамдинсүрэнгийн мэндэлсний зуун жилийн ойг зохион
байгуулах хорооны дарга, Монгол улсын Засгийн газрын гишүүн
Боловсрол Соёл Шинжлэх Ухааны сайд*



Н. Болормаа

ОРШИЛ

Ардын уран зохиолч, академич Ц.Дамдинсүрэн Монголын дорнод их тал нутагт чухам ардын аман зохиол, бичгийн уран зохиолын баялаг шимтэй хөрснөө өсөж бойжсон хүн юм. Тэрбээр гэнэн бага ахуйдаа “Гэсэр”, “Жангар” зэрэг алдарт туульс сонсож, хувийн номын цуглуулгаас уншиж хүмүүжсэн байна. Энэ тухай өөрөө ч бичиж ярьсан зүйл цөөнгүй нийтлэгдсэнийг уншигч олон андахгүй буй заа.

Улмаар эрдэм судлалын их замд орсон үедээ ч “Монголын уран зохиолын гурван их оргил” хэмээсэн “Монголын нууц товчоо”, “Гэсэр”, “Жангар” зэрэг эртний уран зохиолынхоо томоохон дурсгалууд дээр тэгш анхааран амжилттай ажиллаж их зүйлийг бүтээсэн гэж болно. “Монголын нууц товчоо”, “Гэсэр”-ийн талаар үлэмж бүтээл туурвисныг дэлхийн монгол судлал дахинаар мэдэх болжээ. Харин Жангарын туулийн тухайд чухам дорвийт юм юу бүтээсэн вэ? гэдэг асуулт гарч болох юм.

Үүнд хамгийн товчоор хариулахад монгол тутургатан хотлоороо тэмдэглэж буй “Жангар” туулийн 550 жилийн ойг тохиолдуулан анх удаа хэвлэхээр зэхсэн Ц.Дамдинсүрэнгийн нэмэн засварлаж шүлэглэсэн 3500 мөр шүлэг бүхий гар эхээрээ үлдсэн энэ бүтээлийг хэлэх нь зүй. Энэ бол 1963 онд Улаанбаатарт хэвлэсэн Жангарын эхний дөрвөн бүлгийг нэмэн засаж шүлэглэсэн гар эх болно. Үүнд бяцхан зүйлийг тодруулбал дээрх хэвлэлийн 2500 орчим мөр шүлгээс (21 мөрөөр машиндсан 140 хуудас) 1000 мөрийг огоот хасаж, 1000 мөрийн цөөн үтийг орхин үлдээж засварлан шүлэглээд цоо шинээр 1000 хол илүү мөр шүлэг нэмж оруулсан байна.

Чингэхдээ уг туулийн шүлгийн уран сайхныг уншигч нарт улам ойлгомжтой сайн болгож үнэхээр ардын уран зохиолчоо илтгэж харуулах мэт алхамаар бус алдаар урагшлуулсан хэмээлтэй.

Жангарын тууль гэдэг зохиолын дотор уран яруу хэллэг, цэцэн мэргэн үг зөндөө баялаг байвч бүхэлдээ хараахан тийм биш учир засан сайжруулж шүлэглэх хэрэгтэй гэж багш эртнээс бодсоор ажлын чөлөөг харан аятайхан болгож шүлэглэсээр басхүү эхний хэдэн бүлгийг гараас гаргах тийш хандуулсан билээ.

Харин урьд хожид дотоод гадаадад тэмдэглэж, хэвлэсэн олон бүлгээс сонгон боловсруулж нэгэн иж эхийг уран яруу хэл найруулгатайгаар хэвлүүлэн уншигч түмэндээ өргөн барихыг чухалчлан ярьдаг байсан боловч амжаагүй нь харамсалтай. Би хувьдаа дахин дахин дурдаж чихийг нь цөөнгүй удаа халууцуулан хонх уяж байсан билээ. Учир нь туслан ажиллах надад бичүүлсэн хөтөлбөр жагсаалтын 10 дугаарт “Жангарыг орчуулах буюу сонгомол эх боловсруулах” гэж байсан ба ер нь ийм олон нийтэд зориулсан эх хэрэгтэй зэргээс шалтгаалсан юм. Гэвч амьдралын эцсийн хэдхэн жилд хийх ажил их, зав цаг бага замын бартаа үлэmj байсан тул бодовч бодын шийр дөрөв болж гүйцээж баралгүй багш маань таалал төгссөн юм.

Ерөөс Ц.Дамдинсүрэн бүр хүүхэд ахуй үедээ нутгийн жангарч нараас уг зохиолыг мэдэж авсан бөгөөд эртнээс анхаарч байжээ. Үүнд цөөн баримтыг дурдвал 1940 онд их эрдэмтэн багш Н.Поппедоо бичсэн “чухал түүхт” захидалд “Дөрвөдөөс нэгэн Жангарын вариантыг бичүүлж авсан нь хоёрхон бүлэг бөгөөд төдийлөн уран бус мэт” хэмээжээ. Түүнчлэн 1940 онд Жангарын туулийн 500 жилийн ойг тэмдэглэх үед Зөвлөлт улсад хэвлэсэн сонины хайчилбар мэдээ ч болов гэр музейд нь буй Жангар судлалын номуудын завсар хагас зуун жилийн өмнөх дурсгал хэрэглэгдэхүүн болон үлджээ. Бас Жангарын холбогдолтой ном, мэдээг тасралтгүй цуглуулан эрдэм шинжилгээний бүтээлдээ дурдсан зүйл ч нэлээд бий. Мөн 1957 онд Өвөр монголд, 1963 онд Өөрийн улсад хэвлэсэн “Жангар” номонд удаа дараа сайхан оршил бичиж эрхлэн хэвлүүлжээ.

1957 онд Мүгдэн хотод хэвлэсэн “Жангар” номын “Хэвлэн нийтлэгчийн үг”-ийн дунд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын

хэл бичгийн дэд эрдэмтэн Цэ.Дамдинсүрэн авгай манай энд ирсэн тохиолдож, маш яаралтай байсан цагийн дотор бидний мэдээгүй нэлээд үгсийг тодорхойлон тусламж үзүүлж, бас уншигч судлагч олонд зориулан бүх агуулгыг хамарсан утга төгөлдөр оршил бичиж өгснийг талархан тэмдэглэх хэрэгтэй байна” гэсэн нь хэр зэрэг бэлэн мэдлэгтэй явсан хийгээд байнга алдарт туулиа анхаарч байсны тод томруун гэрч болно.

Бас 8 настай балчир үедээ тогтоон цээжилсэн Жангарын туулийн зарим мөрийг ч марталгүй бодсоор 80 настай буурал ётгөс болтлоо үзсэн хувилбаруудын дотор тэрхүү

Талын чинээ цагаан цээжийг

Уулын чинээ улаан өвдгөөрөө дарж суув¹

гэсэн мөр тохиолдохгүй байна хэмээн хуучлан ярьсныг нь өмнө бид нэгэнт нийтлүүлснийг цухас тэмдэглэхэд илүүц бус болов уу.

Мөн Дамдинсүрэн багш эртний уран зохиолын хичээлийг их сургуульд зааж байх үедээ энэ туулийг чухам бахтай хавтай ярьдаг, хуучин үгийнх нь утга учрыг урамтай оновчтой тайлбарладаг, судалсан тэмдэглэсэн тойм зэргийг нь тун ч сайхан хэлж өгөн, машид чадварлаг заадагсан хэмээн Монгол улсын их сургуульд 1950-аад оны дунд үес оюутан байсан монгол хэлний анги төгсөгч Н.Дагвадорж нарын зэрэг нэг биш ахмад хүн надад хуучилсан билээ. Багшлах ажлынхаа зэрэгцээ бэлтгэсэн “Зуун билэг” хэмээх алдарт цоморлогтоо ч мөнхүү туулиас нэлээд аятайхан хэсгийг нь сонгон оруулсныг хэн бүхэн андахгүй билээ.²

Бүр хөндлөнгийн мэт нэг зүйлийг дурдахад “Үнэн” 1967-IY-I0 (№100/I0095) гэсэн сонины хайчилбар хэдэн дууны дотор буй

“Жагсаад ирдэг цэрэг нь

Жаран лууны сүртэй

1. Ц.Дамдинсүрэн “Намтын хуудсаас” УБ., 1990, 48-р тал

2. Ц.Дамдинсүрэн “Монгол уран зохиолын дээж зуун билэг оршвой” 1959, 211-221-р тал

Жанжлаад ирдэг Сүхээ нь
Жангар баатрын хүчтэй
Авраад ирдэг цэрэг нь
Арван лууны сүртэй
Аваад ирдэг Сүхээ нь

Абай Гэсэрийн хүчтэй” хэмээх хэсгийг хар бэхтэй үзгээр тойруулан тун эвтэйхэн хайрцаглаж зураад мөн Жангар номын дунд хавчуулан хадгалсан нь ч нягт нямбай ажиллаж холбогдох хэрэглэгдэхүүнийг бага гэлгүй базааж байсныг илтгэнэ. Эдгээр нь Ц.Дамдинсүрэн Жангар туулийг насан турш анхааран судалж сонгомол эх боловсруулахаар зорьж байсны үндэс сурвалж баталгаа нотолгоог тодруулахад тус дэм болох биз.

Одоо чухам уг эхээ хэрхэн яаж боловсруулан сайжруулсан, ямар зүйлийг шинээр нэмж шүлэглэсэн тухай хэдэн жижиг жишээг баримт болгон иш татвал, хэвлэсэн номын I9 дүгээр талд буй³

Баян Хүнхээн Алтан Цээжийн
Барвад алтан байшин нь ч бас харагдав
гэдгийг
Хүнхээн Алтан Цээжийн
Хүрэл алтан байшин нь
Хүдэн дотроос хүглийж
Будан дотроос бундайж
Манан дотроос манхайж харагдав
болгон нэмжээ. Бас 26 дугаар талд байгаа
Наран гарах үд хоёрын
Хоорондуур гараад одов
хэмээснийг

3. “Жангар” Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т.Дүгэrsүрэн,
Редактор Ц.Дамдинсүрэн УБ., 1963

Наран гарах үд хоёрын
Хоорондуур чиглээд явав

гэж зассан нь шүлгийг сайжруулаагүй мэт боловч хоёр үгийг
сольсноор тухайн тохиолдолд утгыг нэлээд оновчтой болгон
тодруулж өгсөн бололтой. Мөн 34 дүгээр талд буй

Тошсон хөдөөлсөн бух болсон

Төөрсөн годил болсон

гэдгийг

Тэвээрсэн бух болсон

Тэнэмэл годил болсон

гэж зассанаа дахин сайжруулж

Тэнэсэн бух болсон

Тээглэсэн годил болсон

хэмээн шүлэглэжээ. Түүнчлэн номын 36 дугаар тал дахь

Өвсөн хоолтой мал зовоохгүй

Аав ээжийн өгсөн

Эгэм далаар үзэлцье гээд

хэмээснийг

“Өвсөн хоолтой малыг зовоохгүй

Өөрийн биеэр үзэлцье.

Аав ээжийн өгсөн

Алд биеэр үзэлцье” гээд

гэх буюу номын 66 дугаар талд

Гуяа ташаад

Олгойгоо хагартал инээв

хэмээснийг нь

Хоёр гуяа алгадаад инээв

Ходоодоо хагартал

Хоолойгоо сөөтөл хөхрөв

гэх мэтээр зүйл бүрээр сайжруулан хэдэн янзын өнгөтэй бэх бүхүй үзгээр дахин давтан засаж байсан нь гар эхээс тодорхой харагдаж байна. Ийнхүү нэмж чимэн засахдаа үлгэр тууль, ерөөл магтаалын хөг аялгууг хэрхэн бахтай сайхан шингээн оруулсныг уг эхтэй нь тулган үзсэн хэн хүн төвөггүй мэдэх нь мэдээж билээ. Мөн цөөн зарим үг, өгүүлбэрт утгын товч тайлбарыг зүүлтийн журмаар багш өөрийн гараар үйлдсэнийг цухас тэмдэглэе.

Чингэхдээ нэмсэн буюу зассан шүлгийн мөр зуу зуугаар биш мянга мянгаар тоологдож буй нь бодтой магадтай зүйл. Энэ нь зөвхөн эхлэл, нэг, хоёр, гуравдугаар бүлэг, дөрөвдүгээр бүлгийн эхний хэсэгт байгаа шүлгийн мөрийн тоон дээр гарсан хэрэг.

Иймд энэхүү Жангарыг хэдийгээр бүрэн бус боловч өмнөх удаагийнхэвлэлийг засааднэмэншүлэглэж сайжруулсан сонгомол эх гэж үзэх үү эсвэл зохион боловсруулсан шинэлэг бүтээл гэж үзэх үү гэдэг нарийн төвөгтэй асуудалд ч тулгарч болох байна. Бүр өөрлөгч нутгийн найрагч Чимэддоржийн шулэглэн зохиосон “Гэсэр”-ийн хэмжээнд үзэж Ц.Дамдинсүрэнгийн зохиол гэж үзэх үү гэвэл үүнд миний бие шууд шийдвэрлэн хариу өгөхөөс түр түдгэлзэн судлагч нарт хэрхэн нэрлэж, ямраар үзэхийг үлдээгээд юуны өмнө уншигч олонд уг эхийг хүргэх хамгийн чухал зорилгоо эрхэм болгох нь зүйтэй хэмээн санав. Ардын уран зохиолчийн авдранд үлдсэн энэхүү томоохон бүтээл нь алдарт Жангарын туулийн амт шимийг ард олонд гүнээ мэдрүүлэхэд мэдэгдэхүйц ач тусаа өгөх нь магад бөгөөд басхүү тууль судлагч нарт болон Дамдинсүрэнгийн зохиол бүтээлийг сонирхогч гадаад дотоодын эрдэмтгэн мэргэд хэн хүнд тустай хэмээн найдаж хэвлэлд бэлтгэвэй.

P. Отгонбаатар 1990 он



ЭХЛЭЛТ

Эртний эхэн цагт гарсан
Энэ олон бурхдын шашин дэлгэрсэн цагт гарсан
Тахь Зул хааны үлдэл
Тансаг бумба хааны ач
Үйзэн алдар хааны хөвгүүн
Үеийн өнчин Жангар билээ.
Эрхэн хоёр насандаа
Догшин мангаст нутгаа дайлуулж
Өнчин биеэр үлдсэн
Гурав хүрэх насандаа
Аранзал зээрдийн үрээ цагт
Хөл өргөж мордсон
Гурван их бэхлэлтийн амыг эвдэж
Гулжин шар мангас хааныг номдоо оруулсан

Дөрөв хүрэх насандаа
Дөрвөн их бэхлэлтийн амыг эвдэж
Дөрвөн их шар мангас хааныг номдоо оруулсан
Эрхэн таван настайдаа
Тахийн таван шулам хааныг
Олзлон авч номдоо оруулсан
Тэр таван настайдаа
Бөх Мөнгөн Шигшрэгт баригдаж
Олзлогдсон билээ.
Зургаа хүрэх насандаа
Зургаан бэхлэлтийн амыг эвдэж
Зуун жадын үзүүрийг хугалж
Зураг болсон байшинтай
Хүнхээн Алтан Цээжийг оруулж
Баатар олон сайчуудын
Барууны ахлаач болгосон билээ.
Долоотойдоо доордын долоон хортныг
Доройтуулан дарж
Дуутай жангар нэрээ дуудуулсан
Аранзал зээрдийн хурдан цагт
Алтан шар цоохор арам⁴ жадын хурц цагт
Өөрийн биеийн өсөх залуу цагт
Дөрвөн тивийн хааны хүүхнүүдийг голоод
Дөчин есөн ноёны хүүнүүдийг бас голоод
Нар гарах үд хоёрын хооронд байдаг
Ном төгс хааны хүүхнийг залсан билээ.
Хүлгүүдийн хурдан хамгийг цуглуванс

4. Арам гэж шиддэг урт жадын нэр.

Хүний чийрэг бүгдийг цуглуулсан
Дөрвөн талын
Дөчин хоёр хааны нутгийг номдоо оруулсан
Үхэлгүй мөнхийн оронтой
Үргэлжид хорин таван насны дүрээр байдаг
Өвөлгүй хаврын хэвээр
Зунгүй намраар
Даарах хүйтэнгүй
Халах халуунгүй
Сэр сэр гэсэн салхитай
Бур бур гэсэн хуртай
Бумбын орон болно.
Тансаг бодын
Таван сая албат нь
Таван сарын газарт
Арай багтмаар буурилсан байдаг
Өл Манхан Цагаан уул нь
Өндөр хөх тэнгэрийн түшиг болоод
Өргөн шар дэлхийн хүйс болоод
Өглөө гарах нарны доор
Манхайгаад байдаг гэнэ.
Өргөн Шартаг гэдэг далай нь
Орүү сөрүү хоёр урсгалтай
Өнгөтэй бадмын гэрэл гаргаад байдаг гэнэ.
Эзэн Жангарын өөрийн биеийн уудаг
Хүйтэн Хар Домбо гол нь
Өвөл зунгүй урсгалтай
Үргэлж гадна эргээ балбалан

Булгилан байдаг.
Шатар болсон бумбалваа өргөө нь өөрөө бүтсэн
Шарын дөрвөн төрөө гар дээрээ авсан,
Шар наран доорхоо эзэлсэн
Эзэн ноён гэх нэрээ
Их хол газар тархаасан байдаг.
Эрхэн бумбын орон дотроо
Шарын зургаан мянган
Арван хоёр баатар нь
Суугаад хүүрнэлдсэн үг нь энэ:
“Эзэн ноён Жангартaa
Энэ нарны доор үгүй
Байшин бариулья” гээд
Дөрвөн тивийнхээ
Дөчин хоёр хаанаа цуглувуж ирээд
Ямар хэрийн газарт барья гэж
зөвлөлдөж хүүрнэлдсэн нь:
“Нар гаахын ар бие тал
Гарвид их шилийн энгэр тал
Арын арван хоёр далайн цутгаланд
Бумба далай гэдэг далайн хөвөөнд
Өл Мандах Цагаан уулын
Баруун эрүүн доор
Талбайн Цагаан Ташууд
Таван зуун галбир зандан улиасны сүүдрийг
Дагуулж барья” гэж хүүрнэлдсэн болно.
Дөрвөн тивийн дөчин хоёр хаан нь
Эрхэн шарын зургаан мянган арван хоёр

Урчуудаа дагуулж ирээд
Сарын сайныг сахиад
Өдрийн сайныг онцлоод
Шүрээр дэвсгэр тавиад
Сувдаар хана хийгээд
Ар биеий нь
Арслангийн соёо гарган
Шахан ханалсан
Өмнө биеий нь
Өл бугын соёогоор
Шахан ханалсан байна.
Ирсэн ерэн есөн жилийн юмыг
Тоочиж хэлдэг
Ирээгүй ерэн есөн жилийн юмыг
Тааж мэддэг
Баян Хүнхээн Алтан Цээжийн
Хүнгэнэж хэлж байсан нь:
“Огторгуйд хүргээд барихлаар
Их дориун болох боловч
Эзэн ноён Жангарт
Сайн болохгүй
Огторгуйгаас хуруу дутуугаар
Баригтун” гэж байв.
Шарын зургаан мянган
Арван хоёр урчууд нь
Шавхаж хүчээ гаргаад
Тал дундуур нь татуурдаад
Таван их шанаа гаргаад

Гарах тал биеий нь
Гажиг шилээр өнгөлсөн
Орох тал биеий нь
Усан шилээр өнгөлсөн
Ар биеээр нь өвөлжсөн улс
Айраг хярмаар мялааг гээд
Алаг бугын арьсаар өнгөлсөн
Өмнө биеээр нь өвөлжсөн хүн
Өөх тосоор мялааг гээд
Өл бугын арьсаар өнгөлсөн
Гадаад дөрвөн өнцгий нь
Гал шилээр нүдэлсэн
Дотоод дөрвөн өнцгий нь
Догшин болдоор товчилсон
Дуутай Жангарын арван давхар
Есөн өнгө алтан торлог байшин нь
Дөрвөн талынхаа
Дөчин есөн жилийн хортон дайсныг
Даран далбайн дүнхийгээд байв.
Дугтуй дотроо байхлаараа
Толbon сарны гэрэлтэй
Дугтуйнаасаа гарахлаараа
Долоон нарны гэрэлтэй
Алтан шар цоохор тугийг
Өмнө биед нь хатгасан байв.
Тэр бүхнээ эзэлсэн
Эзэн Жангар нь
Дөчин дөрвөн хөлтэй



Дүнхгэр сайхан ширээн дээрээ
Дүүрэн гарсан арван тавны сар мэт
Мандаж суудаг болно.
Арван зургаатай
Агай Шавдал хатны
Шар болд хайчаар хайчилж
Шадар сайччуулын хатдаар оёулсан
Хар торгон тэрлэгээ
Ханцуйлалгүй сүл нөмрөөд
Хараацайн живэр сахлаа илбэн
Энгийн олон баатрууддаа
Төр шажин хоёроо
Зарлиг болоод суудаг болно.
Аранзал зээрдийн хурдан цагт
Алтан шар цоохор жадын хурц цагт
Өөрийн биеийн залуу хөөрүү цагт
Дөрвөн тивийн хааны
Дөчин есөн нутгийн хүүхнүүдийг голоод

Наран үд хоёрын хооронд байдаг
Ном Төгс хааны хүүхэн
Арван зургаатай агай Шавдалыг
Авч ирсэн нь ямар дүрээр байна гэвэл:
Цаашаа харахад нь
Цаад далайн жараахай тоологдом
Наашаа харахад нь
Наад далайн жараахай тоологдом
Цуснаас улаан хацартай
Цаснаас цагаан санчигтай
Уран ээжийн эсгэсэн
Олон хатан зөвлөж оёсон
Цастьын цагаан малгайг
Зүүн цох дээрээ тавин суудаг болно.
Сайхан гөрмөл үс нь
Санчгийг даган унжаад
Хар торгон шивэрлэг /үсний гэрэвч/ нь
Хацры нь даган ганхаад
Тором тэмээний хоргол шиг
Толь мөнгөн сүйх нь
Гүмбэ чихэнд нь дүүжлэгдээд
Гүрээ талд нь гэрэл гаргаад байдаг болно.
Ерэн нэгэн чавхдастай
Ендэр мөнгөн хуураа аваад татахлаар
Хулсан дунд өндөглөсөн
Хунгийн дуу гараад
Нуур дунд өндөглөсөн
Нугасны дуу гараад

Арван хоёр аясаар
Хангинаад гарав.
Үүнийг алдалгүй дагадаг нь
Хэн бэ? гэвэл:
Эзэн богд Жангарын
Эрхэн сайн сөнч
Эрх Тугийн хөвгүүн
Орчлонгийн сайхан Минъян болно.
Баруун биеий нь ахалж суудаг нь:
Ирсэн ерэн есөн жилийн юмыг
Тоочиж хэлдэг
Ирээгүй ерэн есөн жилийн юмыг
Тааж мэддэг
Баян Хүнхээн Алтан Цээж
Далан хааны нутгийн төр шажин хоёрыг
Гар дээрээ бариад
Ямар их бэрх зарга ирэвч
Төдөлгүй хагалаад
Хар торгон олбог дээр суудаг гэнэ.
Зүүн биеий нь ахалдаг нь:
Түвшин Ширхэгийн ач гэнэ.
Бөх Мөнгөн Шигшрэгийн ууган хөвгүүн гэнэ
Шилтэй Зандан Гэрэл хатны
Эрхэн хорин хоёр настайд нь гарсан
Арслангийн Араг Улаан Хонгор гэнэ.
Хайр цагаан далаа хамхчиж
Хамаг биеэ хүүчиж
Далан хааны нутгийг

Дангаар оруулж өгсөн гэнэ.

Хонгорын дараа суудаг нь:

Тавлаад суухлаараа

Тавин хоёр хүний зайд суудаг

Тахийгаад суухлаараа

Хорин таван хүний зайд суудаг

Баатар Бумбын орондоо

Хүйтэн хар шороороо нэр гарсан

Зааны таваг хайсан хар хүлэгтэй

Гүзээн Гүмбэ гэдэг баатар нь

Мянган нэгэн жилийн

Төр шажин хоёрыг

Булаалдаж хэлэн суудаг.

Хүнхээн дараа суудаг нь:

Сарваа цагт нь

Сайн болно гээд

Сая өрхөөр авсан

Хүүхэн хүрэн халзантай

Наян нэгэн алд

Хайв балтыг эгэмнээсээ салгадаггүй

Залуу чийрэг ямар боловч хүнийг

Морин дээр нь тогтоодоггүй

Хүний начин

Хүнд гарч Савар болно.

Зүүн талын гуравдах нь:

Буян төгс ааваа

Хөвгүүнгүй хаяад

Бурхан сайхан ээжээ

Буянгүй хаяад
Буман өрх албатаа
Ноёнгүй орхиод
Арван наймтай
Ангир улаан хатнаа
Ганц биеий нь хаяад
Буурал халзнаараа ирж
Эзэн богдыг дагасан
Булингарын хөвгүүн
Догшин хар Санал болно.
Эд мэт баатрууд нь
Энгийн олон сайдуудтайгаа
Эндээ долоон тойрог болоод суудаг.
Цал буурал сахалтай
Цагаан өвгөд нэг тойрог болоод
Эелдэг улаан эмгэд нэг тойрог болоод
Цуутай цагаан бэрүүд нэг тойрог болоод
Цулцгар улаан хүүхэд нэг тойрог болоод
Эмнэг гүүний айраг
Элбэг арзын найр болоод суудаг гэнэ.
Эрхэн шарын зургаан мянган
Арван хоёр баатрын
Гэгээн царай нь улайж
Гэдэс дотор нь халаад ирэв.
Ийшээ тийшээ хараад
Ингэж ярилцаж гэнэ:
Халдах дайсан
Хаанаас ирэх вэ?
Харагдсан дор нь

Хамх цохиж устгая.
Хэнээрхэх дайсан
Хэзээ ирэх вэ?
Хэрцгийлсэн дор нь
Хэмх цохиж устгая.
Ан гөрөөс хaa байна ?
Ав хоморго хийе гэж
Арван хуруугаа атгаж
Алаг нүдээ эргэлдүүлж байв.



АЛТАН ЦЭЭЖ, ЖАНГАР ХОЁРЫН БАЙЛДСАН БҮЛЭГ

Алдарт ноён Жангарыг эрхэн таван настайд нь
Түвшин Ширхэгийн хөвгүүн
Бөх Мөнгөн Шигшрэг олзолж аваад
Өөрийн оронд байлгасан цагт
Шинжийг нарийнаар шинжлээд
“Энэ нарны доорхи амьтныг
Эзлэм алдар их заяатай хүн болно” гэж
“Үүнийг эрт хороож дарна” гэхээр
Өөрийнх нь хөвгүүн
Эрхэн тавтай Араг Улаан Хонгор
Алдарт Жангарын дээр нь хэвтээд
Аминд нь хор хүргүүлэлгүй байв.

“Одоо яаж хороох вэ?” гэж санан
“Баян Хүнхээн Алтан Цээжийн
Найман түмэн манхан хөх халzan
адууг хөөлгөвөл

Энэ Алтан Цээжийн үүдэн энтэй
Хөх хивэр суманд нь оногдож үхнэ” гэж санаад
Эрхэн зургаа хүрэх насанд нь
Алдарт Жангарыг
Аранзал зээрдий нь унуулаад явуулав.
Наран шингэх үд хоёрын хоорондуур чиглэж
Нарийхан зээрдээ унаад
Найман түмэн адуугий нь хөөхөөр гарав.
Эгц гурван сарын газарт
Шөнийг шөнө гэлгүй
Өдрийг өдөр гэлгүй давхин одов.
Мориныхоо их хурданд
Эмээлийнхээ хойд урд талд нь ховхолзоод явав.
Дээш дэгдсэн тоос нь
Огторгуйд хүрэн суунаглаад байв.
Дахин гурван сарын газарт давхисанд
Өл Манхан Цагаан уулын орой харагдаад ирэв.
Уулан дээр гарч очоод
Уужим мөнгөн цулбуураа сунгаж бариад
Үрт хар ташуураа түшээд
Хүйтэн хар нүдээрээ дөрвөн зүгийг харав.
Хүнхээн Алтан Цээжийн
Хүрэл алтан байшин нь
Хүдэн дотроос хүглийж

Будан дотроос бундайж
Манан дотроос манхайж харагдав.
Жаран голын олмоор гараад
Далан уулын хөтлөөр даваад
Самбаан ташууд хүрч
Сайхан бэлчиж явсан
Найман түмэн хөх халзан адуугий нь
Нааш нь туугаад гарав.
Хашхираад орхисон дуунд нь
Хамагдаж хураагдаад одов.
Тоосноосоо үргэж гүйгээд
Тооромноосоо жигшиж гүйгээд
Сүүдрээсээ бусгаж гүйгээд
Сүүлийнээсээ үргэж гүйгээд
Дэл сүүл хоёр нь
Дэрвэлзэн хийсэхэд
Дэлдэх ятгын дуу гараад
Ган туурайнаас нь
Гал утаяа манаараад
Хурдан хөлөөс нь
Хуй салхи гараад
Гүйгээд өнгөрсөн газарт нь
Гүн жалга гараад
Харайгаад өнгөрсөн газарт нь
Хад чулуу хамхраад үлдэв.
Алдарт Жангарын аранзал зээрд нь
Агт морийг нэг хайтайл
Аятай сайхан хөлөөрөө

Арав хүртэл харайгаад
Нэг ч морийг салгалгүй хөөв.
Нэхсэн хүнд гүйцэгдэлгүй хөөв.

Эзэн Жангар

Элбэг гурван долоо хоногт
Энэ адуугий нь хөөж явтал
Араас нь Баян Хүнхээн Алтан Цээж
Агсам улаан морио унаад нэхэв:
“Энэ миний хөх халzan адууг
Элдэж хөөсөн хүн
Түвшин Ширхэгийн хөвгүүн
Бөх Мөнгөн Шигшрэгийн орноос ирсэн
Алдарт ноён Жангар бололтой.

Долоон насандаа намайг
Доройтуулж эзлэх зяатай байтал
Зургаан насандаа над
Зуурдаар халдаж ирсэн
Зулзага миний гарг орно” гээд
Үүдэн энтэй хөх саадгаа зүүгээд
Үүлэн өнгөтэй хар жадаа бариад
Агсам улаандаа мордоод
Ар талаас нь нэхэж
Гурван долоо хоноод
Гал үдийн эхэнд гүйцээд
Гурван голын цаанаас харвав.
Үүдэн энтэй хөх саадгийн сум нь
Далаар нь ороод голы нь шүргээд гарав.
Ухаан юугаа алдаад



Унах шахсан эznээ
Унаган сайхан зээрд нь
Унагалгүй дэмжиж аваад
Хөөж явсан адуугаа хаяад
Хөндлөн тийшээ чиглэж гараад
Бөх Мөнгөн Шигшрэгийн нутгийг зориод
Бөөн тоос манарагж давхиад
Бөртийх бараагаа далдалж давхиад
Бөх Мөнгөн Шигшрэгийн
Хаш мөнгөн үүдэнд нь
Хайртаа Жангараа аваад ирэв.
Хариугүй ядарсан эзэн нь
Хаалганы өмнө ойчив.
Бөх Мөнгөн Шигшрэг
Хурдан хараа эмээллуулээд
Хурц зэр зэвээ агсаад
Шилтэй зандан Гэрэл хатнаа

Шируүн харж хэлэв:
Тамираа барсан энэ хүүг
Тас цавчиж алаад
Тахиа нохой хоёрт идүүл!” гээд мордоод явав.
Шигшрэгийн явсан хойно
Шилтэй зандан Гэрэл хатан нь
Шийдэм бариад цохих гэтэл
Араг Улаан Хонгор хүү нь
Арайхан завдаж ирээд
“Наадхыгаа алах гэж байгаа юм бол
Намайг бас алагтун” гээд дээр нь хэвтээд байв.
“Даланд нь орсон сумыг
Даруй сугалж хайрла, ээж минь
Ариун явдалт эхнэр хүн
Алхаж гурав гарвал
Аюулт сум нь сугарна” гэв.
Хонгор хүүгийн сэтгэлийг бодоод
Хоёр алхаад гурав дахь дээр нь
Хорт сум нь огшсон боловч
Хойш шигдэж саатаад байв.
“Ээж ээ! Энэ яагаад ингэв?” гэж
Энхрий Улаан Хонгор асуусанд
Эх нь хариу хэлэв:
“Хадамд ирсний хойд жил
Хаврын эмнэг гүүгээ саахаар яваад
Азарга гүү хоёр нийлэхийг
Ажиглаж тачаасны гэмээр
Адраатай сум гараахгүй байна” гээд

Гараа хавсран наманчилж
Газар тэнгэрт залбиран сөгдөхөд
Гайт сум сугарч унав.
Алдарт Жангэр нь үсэрч босоод
Аминдаа орсон ачит
Араг Улаан Хонгортой хоёул
Эгшиг дуугаа дуулалдаад
Элбэг арзын сөн түшээд суув.
 Өдий төдий удсан боловч
Эзэн Шигшрэг эс ирсэнд
Эрхэн Шилтэй Зандан Гэрэл хатан
Энэ хоёр хөвгүүнийг “Нааш ир” гэж
 дуудан аваад
“Эзэн шигшрэг тань одоо хүртэл
Эргэж ирээгүй учир юу вэ?
Араас нь явж эрэгтүн!” гэж хэлэв.
Аранзал зээрд хөх халzan хоёрыг эмээллүүлээд
Элдэв олон зэр зэвээ агсаад
Эрхэмсэг сайхан хувцсаа өмсөөд
Энэ хоёр хөвгүүн мордоод
Элбэг сайхан хурдаар нь гараад
Шилтэй уулын бэлээр хүрээд иртэл
Шигшрэгийг саяхан
Хүнхээн Алтан Цээж
Хүлж баглаж аваад
Хүлэг моринд нь ачаад
Хөтөлж явахыг нь хараад
Хүчит хоёр баатар

“Хүүе!” гээд дайрав.
Баруун талаар нь нэг нь
Балбаад оров.
Зүүн талаар нь нөгөө нь
Зүсээд оров.
Хүнхээн Алтан Цээж харан шинжлээд
“Алдарт ноён Жангэр
Араг Улаан хонгор хоёр
Анд болж нэгдсэн цагт
Амь өрж тэмцээд тусгүй
Аргыг олж дагасан дээр” гээд
Ачсан Шигшрэгийн хүлгийг тайлаад
Анд хоёр баатрыг угтаж уулзав.
Хүндэт дөрвөн баатар
Хүчтэй хүлгүүдээ сойгоод
Болдын сайнаар богочлоод
Төмрийн сайнаар тушаад
Урт сайхан цулбуураа сунгаж бариад
Уулзаж сайхан ярилцав.
Хүнхээн Алтан Цээж нь
Хүнгэнэж хэлэн суув:
“Энэ Жангэр долоо хүрэх насандаа
Доордын олон хортныг доройтуулж
Дуутай Жангэр нэрээ
Дуудуулж алдарших цагт
Аймаг улсаа эзлүүлж
Адуу малаа эдлүүлж
Төр шажин хоёры нь

Түвшитгэн бариулагтун” гэж
Бөх Мөнгөн Шигшрэгт хэлж байна:
“Ноён Жангарын идэр насанд нь
Ном төгс хааны хүүхэн
Агай Шавдалыг залж
Амраг хатан болгогтун!
Ар Бумбын орноо төвхнүүлж
Амар сайхан жаргах тэр цагт
Баруун биеий нь ахалдаг баатар нь
Баян Хүнхээн Алтан Цээж би болно.
Зүүн биеий нь ахалдаг нь
Зүүдэн болсон Улаан Хонгор болно.
Дөрвөн талдаа байсан
Дөчин орныг номдоо оруулж
Төр шажин хоёроо гар дээрээ авч
Түмэн олноо бүрэн захирч
Алдарт дуутай Жангарын
Ар Бумбын оронд
Аз жаргалaa эдлэх болно”
Айлдаж хэлээд
Анд болсон Баян Хүнхээн Алтан Цээж нь
Агсам улаанаа унаад
Ар нутгаа зориод
Адуугаа туугаад гарав.
Ард нь үлдсэн
Араг Улаан Хонгор
Аав Шигшрэгтэйгээ
Алдарт ноён Жангартайгаа мордоод

Алтан торлог байшиндаа ирээд
Амар сайхан жаргалаа хийгээд
Арз хорзын дээжээс
Амсаж уугаад суув.
Энэ жилийн дараа
Эзэн ноён Жангэр
Тивийн дөрвөн хааны хүүхнийг голоод
Ном Төгс хааны хүүхэн
Агай Шавдал хатныг залаад
Төр шажин хоёроо гартаа авч
Тахь Зул хааны үлдэл
Тансаг Бумба хааны үр
Үйзэн Алдар хааны хөвгүүн
Үеийн ганц Жангэр гэж цолоо дуудуулав.



ХОНГОРЫН ГЭРЛЭСЭН БҮЛЭГ

Долоон тойрог болж суугаад
Дориун хар арзаа аягалаад
Дотнын үгээ ярилцаад найрлав.
Арслангийн Араг Улаан Хонгор
Алдарт Жангартай хүслээ гарган хэлэн байв:
“Алдарт ноён богддоо мэдүүлэх минь
Арван найман насандaa би
Алд бие ганцаар яаж байх вэ?
Анхаарч хайрла, эзэн минь!” гэхэд
Алдарт Жангартай мишээгээд
Араг Улаан Хонгорт хэлэв:
Ар Бумбын орны
Аранзал зээрдийг минь тохтугай”
гэж зарлиг болов.

Хүлэгч Бор Магнай баатар
Хүний хэнхдэгийн чинээн хазаары нь
аваад гарав.

Хүйтэн булгийн усыг ууж
Хөх дэнжийн өвсөнд бэлчсэн
Хүлэг олон морьдын дотроос
Алдарт ноён Жангарын
Аранзал зээрдий нь бариад
Алтан шар цоохор байшингийн
Хажуу талаар тойрч
Хаш мөнгөн үүдэнд ирээд
Болдын сайнаар богочлоод
Төмрийн сайнаар тушаад,
Тансаг мөнгөн цулбуураас нь
Тавин сайн хөвгүүдээр
Тавтай сайн бариулаад тохов.
Зулхай цагаан зөөлөвчий нь тавив.
Зургаан давхар тохмы нь тавив.
Зузаан хар эмээлий нь тохоод
Зурvas мөнгөн олонцгий нь тавив.
Олом жирмийн оосор хэлхээ
Наян найман горхийг
Навчин хээтэй цоохор гөлмийн доогуур
Дахин дахин татаад
Давхар цагаан харвинд нь
Далан хоёр хуниаслуулаад
Найман татуур хавирганы нь
Нарийн заагаар оруулан татав.

Зураа талд нь
Зуун найман хонх зүүгээд ирэв.
Хүзүүн талд нь
Хүрэл найман хонх зүүгээд ирэв.
Хурдан биеэ
Ялман сайхан хaa дээрээ хураагаад
Хурц биеэ
Хоёр нүдэн дээрээ хураагаад
Сайхан биеэ
Сайр дээрээ хураагаад
Наян найман алд сүүлээ
Намируулан хийсгээд ирэв.
Зургаан төө чихээ
Зуур зуур солбиод
Өрмийн иш соёогоороо
Өлгий мөнгөн зуузайг хавираад
Сагсгар сайхан хөхлөөрөө
Сар нартай наадаад
Хар болд туурайгаараа
Хамаг орныг гишгэм болоод
Тансаг мөнгөн цулбуураас нь барьсан
Тавин сайн хөвгүүдийг
Татаж унагах шахаад
Дечин есөн хоногийн газарт давхихаа санав.
Алдарт богд Жангарт
Арван зургаатай Агай Шавдал хатан нь
Ангир торгон тэрлэгий нь
Авч өмсгөв.

Гунан шарын арьсаар голлож
Гунжан үнээний арьсаар хөвөөлж
Хорт могойн зоог дууриалгаж гөрсөн
Могойн шүлсээр шүүлсэн
Мойлын шүүсээр өнгөлсөн
Шижэр алтаар хээлсэн
Шилдэг болдоор товруулсан
Залуу зандангаар ишилсэн
Залаа торгон сагалдартай
Бараан хар ташуураа
Баруун алгандаа барьж
Шүүсийг бурзайтал атгаад
Шүлтийг нь гаргал базаад
Олон сайчул дундаа
Онц зарлигаа буулгав:
“Арслангийн Араг Улаан Хонгорыг
Залуу хөөрүү байхад нь
Замбал хааны охин
Зандан Гэрэл хүүхэнд
Сүй тавихаар явна би” гэв.
Баруун талаас
Баян Хүнхээн Алтан Цээж нь
“Алдарт Жангар минь аznаж хүлээгтэн!
Ах хүний зөвлөгөөг
Авах хэрэгтэй” гэж байна.
“Бумбын оронд намайг
Бууж өгөөгүй байхад
Агсам улаан морийг минь

Аагтай хурдан байхад
Өөрийн энэ биеийг
Өнгөтэй чийрэг байхад
Шарай голын гурван хааныг
Шамдаж байлдъя гэж
Шаардаж очсон боловч
Шалттай юм болсонгүй
Эргээд явах замдаа
Эзэн Жангариныханд орж өгсөн
Эрт тэр цагт
Эрхэн Бөх Мөнгөн Шигшрэгт
Эрийн зэрэгт хүрч байгаа
Эрэлхэг нэг хөвгүүн бий гэж санаад
Замбал хааны нутгийн
Захаар явж гарахдаа
Ар тийшээ нэг удаа
Ажиглаж нэг хараад
Алив байдлыг шинжилсэн билээ би.
Гурван настай тэр хүүхний байдлыг
Гучин зургаан цонхны нь гэрэлд харлаа.
Ерэн есөн торгоны захыг
Ижилсүүлж нийлүүлж суугаа нь харагдлаа.
Үзэгдэх өнгө байдал нь
Үнэхээр сайхан дагина боловч
Дотор байгаа санаа бодол нь
Тун ч муухай шулам байлаа.
Газрын хүүхнүүд дууссан биш
Гайт тэр хүүхэнд сүй битгий тавь!

Орны хүүхэн барагдсан биш
Олиггүй тэр хүүхнийг битгий авчир” гэж
Хүнхээн Алтан Цээж
Хүнгэнэж хэлж байна.
Эзэн богд Жангар нь
Энэ үгий нь сонсоод
“Зөв гэсэн миний үгийг
Зөрж буруу гэв үү чи?
Зөн билгээр юм мэддэг байлаа чи.
Зөв буруу хоёрыг ялгаж чаддаг байлаа.
Зөнөг болоод одоо тэнэг болжээ чи.
Хэлнээс чинь гарсан үг
Хээрийн салхинд хаягд.
Шүднээс чинь гарсан үг
Шүлс цэр болж хаягд”
Ухасхийж босов.
Урагш дэвшиж гарав.
Дэргэдэх арван хоёр сайд нь
Дэмжиж түшээд гарав.
Таж мөнгөн үүдийг татахлаар
Таван мянган хонх жингэнээд
Түлхээд гаражлаар
Түмэн хонх жингэнээд
Аранзал зээрдийн ойр хүрээд ирэв.
Ард нь Баян Хүнхээн Алтан Цээж
Айлтгаж хэлсэн үг нь:
“Долоон үед нь унаа болсон
Домбын аранзал зээрд нь

Махандаа өөхгүй болж гундаад
Ясандаа чөмөггүй болж ягдаад
Алдарт ноён Жангарын
Ар бие нь наранд өгөршөөд
Өвөр бие нь салхинд цохигдоод
Алтан шар цоохор жадаа
Арай гэж дүүрээд
Арга ядаж явах нь үзэгдэх” гэв.
Алтан Цээжийн үгийг авсангүй
Алдарт Жангар яваад
Өлгүүр мөнгөн дөрөөнд
Өлмий гутал хүрмэгц
Өргөн цагаан олонцог дээр
Өндөс гэж үсрээд буув.
Ашдын сайхан ерөөлөө тавиад
Алтан жолоогоо зөв эргүүлээд
Өндөр шар цоохор байшингаа
Зөв эргээд гарав.

* * *

Наран гарах үд хоёрын
Хоорондуур чиглээд явав.
Дугуй шар цоохор олонцгийн захаар
Дуутай долоон мянга давираад
Дуугүй долоон мянга давираад одов.
Хурдан хүлэг морь нь
Хувьтай эзнийхээ санаагаар

Өмнө хоёр хөлөө
Өдрийн газарт
Хойд хоёр хөлөө
Хоногийн газарт тавиад одов.
Эрүүгээрээ газар шүргэн гүйгээд
Өвчүүгээрээ өвс шүргэн гүйгээд
Хамраас гарсан амьсгаанд нь
Хажуу талын өвс ярагдаад
Хавирган талаас нь харсан хүнд
Өлөнгөөс боссон
Өл халзан туулай мэт
Өвсний дээгүүр өрөвхийгээд одов.
Долоон долоо
Дөчин есөн хоног давхив.
Болзоотын бор толгой дээр
Богд Жангар гараад ирэв.
Аранзал зээрдийг сойгоод буув.
Болдын сайнаар богочлоод
Төмрийн сайнаар тушаад орхив.
Уялга мөнгөн цулбуураа сунгаж бариад
Үрт хар ташуураа
Үрдаа түшиж суугаад
Хоёр хар нүдээрээ
Хол ойрыг ажиглав.
Нар гарах үд хоёрын хооронд
Замбал хааны хүрэл хар байшин
Ассан галын дөл мэт улалзаж харагдav.
“Энэ Замбал хааны байшин

Эрхбиш мөн бололтой” гээд бас хаав:
Түүний наад биед
Арслан гэдэг уулын бэлээр
Ачаа хөсөг шиг юм гараад
Айсүй яваа харагдав.
Аранзал зээрд дээрээ мордоод
Аштай сайхан хурдаар нь морилов.
Арслан уулын бэлээр
Амдаж угтаад очив.
Тавин сайн хөвгүүн
Таван зуун тэмээнд
Тансаг архи идээгээ ачиж ирээд
Талбаг олбогоо дэвсээд:
“Алдарт богд Жангар
Ажаарч хайллагтун” гэж
Морий нь аваад буулгав.
Арван тавны сар мэт дүнхийгээд
Алтан олбог дээр нь гараад суув.
Амар мэндий нь асуугаад
Авчирсан идээ унды нь зооглов.
Сайдуудын хөвгүүд мөргөн сөгдөн
Сайн үгээ тоочин хэлэв:
“Манай Замбал хаан
Мандах нарны зүгээс
Манлай Жангар айсүй гээд
Манийг тосуулсан билээ” гэж байна.
Баярлаж “Сайн” гэж зарлиг болоод
Бахдаж Аранзал дээрээ дахин мордов.

Хатир сайхан хурдаар нь давхиад гарав.
Хар хүрэл байшинд нь хүрээд
Хажуугаар нь тойров.
Бумба далай гэдэг далайн хөвөөнд
Бум гүйцээд буурилсан хурлы нь зөв эргэв.
Аранзал зээрд нь
Бүдүүн өвсийг бөхийлгөлгүй
Бөмбөлзүүлэн жороолуулж
Нарийн өвсийг нахийлгальгүй
Намилзуулан сайварлуулж явсаар явна.
Хүрэл хар байшингийн нь үүдэнд
Хүрээд очив.
Сүндэрлэж үүдэнд нь ургасан
Сүрлэг гурван зандан улиасны
Сүүдэрт нь очоод буув.
Арван хоёр сайд нь угтаж ирээд
Аранзал зээрдийг нь аваад уяв.
Арван дөрвөн үүдийг нь
Ангас ангас татаад
Агар зандан босгыг нь
Алхаж гишгэж даваад
Алтан торлог байшинд нь
Алхайгаад оров.
Баруун талд нь
Байрлуулж зассан
Найман хөлтэй
Нажир мөнгөн ширээн дээр нь
Намбайгаад суув.

Холын зочин, ойрын эзэн
Хоёр хаан мэндээ асуулцан сууна.
Эрхэм сайхан арзы нь ууж
Ээдэй буудай болоод
Элдэв сайхан идээгий нь зооглож
Энгүй өөг болоод
Энх сайхан найрлаад суув.
Нэг долоон хоног
Нэлэнхий ноёдтой найрлав.
Хоёр долоон хоног
Хотол олонтой найрлав.
Гурав дахь долоо хоногт
Жангар ноён зарлиг болж байна:
“Замбал хаан та сонсож айлд!
Зарим алдсан малаа эрж
Зайдуу холоос ирлээ би.
Гурван жилд хамры нь хатгаагүй
Гунан шар тормыг алдлаа.
Хаашаа явсан нь мэдэгдэхгүй байна.
Хайж эрээд олдохгүй байна.
Танай Бумбын оронд ирсэн
Таавар сураг байна.
Тэр тормыг минь олж
Тэмээн сүргийг минь бүрдүүлж хайрла”⁵ гэв.
Замбал хаан зарлиг болж байна:
“Завхсан мал чинь байдаг бол

5. Үнэн зорилгоо тойруулан ёст үгээр хэлж байна.
Замбал хаан ч мөн ёстоор хариулж байна.

Заавал олж өгөх сөн
Үгүй юм болбол
Үхрээс хашин гэдэг биш үү”
Үрэгдсэн тэр тором чинь
Үнэндээ манайд байхгүй” гэв
Тэр үгийг сонсоод
Тээнэгэлзэж жаахан бодоод
Ахиад нэг долоо хоногт
Архийн хурим болов.

Замбал хаан зарлиг болж байна:
“Богд Жангар таны
Бодсон хэргийг мэдлээ би
Над үр болох хүүгээ
Нааш нь ганцааранг илгээгтүн!”⁶ гэв.

Эзэн богд Жангар
Энэ үгийг сонсоод
Ээлтэй сайхан ерөөлөө тавиад босов.

Ээтгэр улаан гутлаараа
Эрдэнэ мөнгөн дэвсгэрий нь
Эгц булц гишгээд
Арван дөрвөн давхар үүдий нь

Ангас ангас хийлгээд гарав.

Аранзал зээрд моринд нь
Ахмад сайдууд нь түшиж мордуулав.
Хүрэл хар байшингий нь зөв эргээд
Хүрээ хороон дундуур нь шуугиулаад гарав.

6. Хүргэн болох хүүг сүйт хүүхний гэрт зохих хугацаагаар суулгадаг ёс урьд байсан.

* * *

Дугуй шар цоохор олонцгийн захаар
Дуутай долоон мянга давираад
Дуугүй долоон мянга давираад авав.
Буцаж долоо хоног давхиад
Бумбын шар цоохор байшингийнхаа
Буурал мөнгөн үүдэнд ирээд буув.
Өөрийн нь олон сайдууд
Өмнөөс нь угтаж гараад
Дөрвөлжин мөнгөн үүдээр нь оруулаад
Дөчин дервөн хөлтэй
Дөш мөнгөн ширээн дээр нь
Дүүрэн гарсан арван тавны сар мэт
Дүнхийлгээд суулгав.
Баатар олон сайдууд нь
Баяртай сайн үгий нь сонсьё гээд
Ар өврөөрөө шахалдаад
Аягатай арзаа бариад сууцгаав.
Тансаг богд Жангар нь
Тамсаг арзаа зооглоод
Тамшаахаас өөр үггүй
Таг чиг суусаар
Тавин хоног өнгөрөөсний дараа
Гэнэтхэн баатрууддаа хандаж
Гэгээн зарлигаа буулгав.
“Сарын сайныг сахиад
Өдрийн сайныг онцлоод
Араг Улаан Хонгорыг



Алсын Замбал хааны нутагт явуул” гэж хэлэв.

Аятай сайн сарын

Азтай сайн өдөр болоход

Хүдэр сайн морьч нь

Хүний хэнхдэгийн чинээн

Хүврээ мөнгөн хазаарыг аваад гарав.

Хөх дэнжийн өвсөнд

Хүйтэн булгийн усанд

Хүлэг олон морьдын дотор явсан

Оцол хөх халzan морийг

Олж хазаарлаж аваад

Орд өргөөгөө чиглээд явав.

Өндөр шар цоохор байшинг зөв эргүүлээд

Өлгий мөнгөн үүдэнд нь аваад ирэв.

Болдын сайнаар богочлоод

Төмрийн сайнаар тушаад

Тансаг мөнгөн цулбуураас нь

Тавин сайн хөвгүүдээр бариулав.
Мөнгөн цагаан зөөлөвчий нь
Мөн зургаан давхар тохмы нь тавив.
Дөш хар эмээлий нь тохов.
Хээ шар цоохор олонцгийн захад
Хэлхээ наян найман горхийг татаад
Далай цагаан харвинд нь
Далан хоёр хуниас гаргаад
Найман татуур хавирганд нь
Нарийхан зураас гарган татав.
Хурдан биеэ
Ялман сайхан хaa дээрээ гаргаад
Хурц биеэ
Хоёр нүдэн дээрээ гаргаад ирэв.
Сайхан биеэ
Сайр дээрээ гаргаад ирэв.
Наян найман алд сүүлээ
Намируулан хийсгээд ирэв.
Зургаан төө чихээ
Зурс зурс солбиод
Өрмийн иш соёогоороо
Өлгий мөнгөн зуузайг хавираад
Дөчин есөн сарын газарт гүйхээ санав.
Сагсгар сайхан хөхлөөрөө
Сар нартай наадаад
Хатан болд туурайгаараа
Хамаг орныг гишгэм болоод
Тансаг мөнгөн цулбуураас нь барьж байсан

Тавин сайн хөвгүүдийг
Татаж дугтарч
Нааш нь нэг налайлгаж
Цааш нь хоёр цалайлгаж байв.
Шилдэг Агай Шавдал хатан
Шилтэй Зандан Гэрэл хатан хоёр
Харь газарт явах хүргэнийг
Хамсаж хувцаслая гэж босов.
Түрий биений нь
Түмэн хүүхэн нийлж шагласан
Зуузай биений нь
Зуун хүүхэн элбэж шагласан
Мөрий нь үзсэн хүн
Мянгаа өгч гайхам
Мөн биений нь үзсэн хүн
Түмээ өгч гайхам
Миймийн улаан гутлаа өмсөв.
Эрээн торгон цамцаа өмсөв.
Эрдэнийн хоёр хүрмээ өмсөв.
Дайны гурван хуягаа зүүв.
Давхар дөрвөн лүвчээ өмсөв.
Далан агт морины үнэтэй
Давтмал луудан гэдэг бүсээ бүслэв.
Далан нэгэн алд
Дархан шар болд илдийг
Баруун ташаандаа зүүв.
Түмэн өрхийн үнэтэй
Түүхий цагаан нөмрөгийг

Дал дээрээ нөмрөөд
Алтан дуулгыг
Зүүн цох дээрээ тавив.
Далан хүн дамжилдаг
Далгай шар шаазанггаар
Дан хар арзыг
Дараагаар далан нэг уугаад орхив.
Гунан шарын арьсаар голлосон
Гунжин үнээний арьсаар хөвөөлсөн
Хорт мөгойн дүр гаргаж гөрсөн
Мөгойн шүлсээр шүүлсэн
Мойлын шүүсээр өнгөлсөн
Шижир алтаар хээлсэн
Шилдэг болдоор товруулсан
Залуу зандангаар ишилсэн
Залаа торгоор сагалдаргалсан
Бараан суран ташуурыг
Баруун гарын алганд
Шүүсийг нь гоожтол атгаж
Шүлтийг нь гартал базав.
Гэгээн царай нь улайж
Гэдэс дотор нь халаад
Магнай дээрх судас нь гөвийгөөд
Малгай доорхи үс нь сэргийгээд
Амин улаан зүрх нь
Аюулхайгаа дэлсээд
Бүдүүн хавирга нь бүлхэлзээд
Нарийн хавирга нь нахилзаад

Арван цагаан хуруу нь
Алган дундаа гөвшилдөөд
Алаг нүд нь ёроолоороо
Арван хоёр эргээд
Аагтай шонхрын нүд гаргаад ирэв.
Араг Улаан Хонгорыг
Алдарт баатруудын өмнүүр
Алхуулж явуулав.
Амраг нөхөд нь
Ажиглаж харав.
Шарын зургаан мянган
Арван хоёр баатар нь
Шалган шинжилж байна:
Ямар зэргийн хүчтэй хүн бэ?
Ялах чадал юутай юм бэ? гэж
Ялган салгаж шинжилбэл
Магнай дээр нь
Махгалын хүч тогтсон
Зулай дээр нь
Зунхавын хүч тогтсон
Орой дээр нь
Очирваанийн хүч тогтсон
Ар биед нь
Арван хоёр
Арслангийн хүч тогтсон
Эрээн сайхан булчинд нь
Эзтэй найман мянган
Шулмын хүч тогтсон.

Далаараа далан таван алд
Давсгаараа наян таван алд
Тал дундуураа
Тавин таван тохой
Ташаа дундуураа
Жаран таван тохой ёргөн
Ийм сайхан эр байлаа.
Морин дээр нь мордуулж нэг шинжлээд
Мориноос нь буулгаж нэг шинжлээд
Шарын зургаан мянган
Арван хоёр баатар нь
Шалгаж үзээд
Өөгүй гэж үзээд
Өчүүхэн ч дутагдалгүй гэж шийдээд
Далан нэгэн буман цэргийн
Дайчин манлай болом гэж хүүрнэлдээд
“Явсан энэ явдлаа
Яг номын ёсоор гүйцээгээд
Ар Бумбын орондоо
Алдарт Жангарынхаа
Алтан мөнгөн үүдэнд
Амар мэнд хүрч ирээрэй” гэж
Ахмад олон сайдууд нь цугаараа ерөөлөө тавив.

* * *

Араг Улаан Хонгор мордоод
Алаг шар цоохор байшинг зөв эргээд

Алтан наран гарах үд хоёрын хоорондуур
Алсыг зориод давхив.
Оцол хөх халзан нь
Өмнө хоёр хөлөө
Өдрийн газарт тавиад
Хойд хоёр хөлөө
Хоногийн газарт тавиад
Эрүүгээрээ газар шүргэн гүйгээд
Өвчүүгээрээ өвс шүргэн гүйгээд
Хамрын нүхний амьсгаанд
Хажуу талын өвс
Халиурч хийсээд
Хавирга хажуугаас нь харсан хүнд
Өлөнгөөс боссон
Өл халзан туулай мэт
Өлөнгийн дээгүүр өрөвхийгээд одов.
Долоон долоо
Дөчин есөн хоногийн газарт гүйлгэв.
Бас Болзоотын их
Бор довон дээр гараад
Оцол хөх халзныг
Сойгоод буув.
Болдын сайнаар богочлоод
Төмрийн сайнаар тушаад
Тансаг мөнгөн цулбуураа сунгаад
Тас хар ташуураа түшээд
Хар сайхан нүдээрээ
Хавийн газрыг ажиглав.

Наран гарах
Үд хоёрын хооронд баригдсан
Замбал хааны
Хүрэл хар байшин
Ассан галын дөл мэт харагдав.
Энэ Замбал хааны байшин
Мөн гэж санаад
“Манай алдарт Жангарын
Шинжилсэн хүүхэн нь
Ямар янзтай вэ?” гээд
Хүүхний шил гарди
Байшин руу нь харав.
Шар наранд хандаад
Шагай чөмгөө барилцаад⁷
Тэнгэрийн Төгөө Бүстэй
Мөргөж байх нь харагдав.
Урагшаа нэг хараад
Ухаанаа хоёр тунгаагаад
Орон нутгaa нэг хараад
Оцол хөх халзнаа нэг хараад
Нааш цааш явж байв.
Удаан яваад байхаар нь
Оцол хөх халзан нь
Болд төмрөө тас цохиод
Эвшээн хэлэн байв:
“Эрхэн арван найман насандaa
Хүн болно гэж гараад

7. Хурим хийхэд хүү бэр хоёрт шагайт чөмөг өгөх ёс байсан.

Ганц бараа үзээд
Харив гэх муу нэрийг яана чи?
Чамтай адил хүн урагшаа
Дайнд ороод үхэвч
Богд Жангарын оронд
Дахиад нэг ийм хөвгүүн
Төрөхгүй гэж бодож байна уу чи?” гэв.
Араг Улаан Хонгорын
Амин улаан зүрх нь булгилаад
Адгийн араа нь
Амандаа тачигнаад мордов.

Оцол хөх халзандаа хэлэв:
“Маргааш өглөө
Нар мандахын цагт
Тэнгэрийн Төгөө Бүст
Намайг хүргэ!” гэж байна.
“Хэрэв эс хүргэвэл
Дөш болсон зоогоор чинь
Хэнгэргийн шир хийнэ.
Хүдэр найман хавиргаар чинь
Хэнгэргийн дохиур хийнэ.
Дөрвөн хар туурайгаар чинь
Зулын цөгц хийнэ” гэв.

Оцол хөх халзан нь тэр үгийг сонсоод
Ар хөлийнхөө шавхайгаас
Үргэн гүйгээд гарав.
“Маргааш өглөө
Нар мандах хүргэл

Миний нуруун дээр тогт.
Сайраар шувтраад унавал чинь
Сайн эзэн минь билээ гэж
Эргэж авахгүй шүү би” гэв.
Гүйсэн нь ч мэдэгдэлгүй
Ниссэн нь ч мэдэгдэлгүй
Явсан их хурданд
Эмээлийн ард суугаад
Алтан жолоондоо
Арай гэж хүч хүрч явна.
Маргааш өглөө нь
Нар мандахын үед
Замбал хааны цагаан өргөөний
Өмнө ирээд буув.

* * *

Оцол хөх халзныг
Төмрийн сайнаар тушаад
Болдын сайнаар богочлоод
Замбал хааны өргөөний
Мөнгөн хатавчий нь
Жингэнүүлэн татах ороод
Баруун хатавчинд нь суув.
Айлчин ирсэн бололтой
Ай чимээгий нь сонсоод
Найман хөлтэй
Нажир мөнгөн ширээн дээр
Есөн давхар

Лавир тортон хөшгийн цаанаас
Ууртай дуу сонстов:
“Миний гэрт зөвшөөрөлгүй ордог
Нүүрэндээ галтай
Нүдэндээ цогтой
Тэнэсэн бух болсон
Тээглэсэн годил болсон
Юун нохой ирэв чи?
Гарч яв!” гэж байна.
“Таныг ийм зантай гэж
Санасангүй би
Нэг азарга адуу алдаад
Гурван сар хайгаад олсонгүй.
Энд нэг айл байхыг хараад
Эрсэн малаа зарлая гэж
Идэх уух юм эрж ирлээ би” гэхэд
“Чамд босож
Үнд хийж өгөх хүнгүй.
Өөрөө босоод хийгээд уу” гэж
Тэнгэрийн Төгөө Бүс хэлэв.
Хонгор босож ирээд
Зүүн биед байсан арзнаас нь
Далан хүн дамжилдаг
Далбагар шар шаазангаар
Дараагаар далан нэг уугаад орхив.
Уг суусан газартаа эргээд суув.
“Үнд уусан залуу
Удалгүй яв” гэв.

“Үнд өгсөн хүн минь
Учиргүй битгий яаруул.
Тамхи татаад гарья” гэж байна.
Гансаа гаргаж тамхия татав.
Амин улаан зүрх нь аюулхайгий нь цохилов.
Бүдүүн хавирга нь бүлхэлзэв.
Нарийн хавирга нь нахилзв.
Арван цагаан хуруу нь
Алган дундаа хавиралдаад ирэв.

“Орсон хүнийг хөөдөг
Олиггүй хүн байна чи.
Наашаа босоод ир.
Нарны галтайд наадъя!” гэж байна.
Тэнгэрийн Төгөө Бүс
Тэлсэн есөн давхар хөшгөө сөхөөд
Хар унаган дахныхаа
Ханцуйнаас чирэн босож ирээд хэлэв:
“Хаа газраас ямар амьтан ирээд
Харин миний уурыг хүргэж байна вэ?” гэж
Ангар ангар инээн
Алиалж дооглож байв.
Гар нүүрээ угаагаад
Гадаа байгаа асман хээрээ эмээллэв.
“Эр хүний үхэл
Эзгүй ээрэм цагаан хөдөөд” гээд
Зэр зэвээ агсаад мордов.
Хоёул хамт явж байтал нь

Ганга мөнгөн далай
Мөсөн цагаан уул хоёр үзэгдэв.
Тэнгэрийн Төгөө Бүс хэлэн байна:
“Над халдсан хүмүүсийн яс
Энэ цагаан уулын
Энгэрт овоорч байна.
Энэ далайн усанд
Цус нь улайрч байна” гэв.
Анх эхлээд манчуургаар нүдэлдэв.
Адаг сүүлд нь
Ташуураар цохицлов.
Орог шар илдээр
Оройноос нь аваад
Охор сүүл хүртэл нь цавчив.
Огтлогдсон шарх нь тэр дороо
Оромгүй болж эдгээд байв.
Ахиад нэг тулахдаа
Алтан шар цоохор
Арам гэдэг жадаар
Авалцан хатгалдав.
Арслан хоёр баатар
Ажиггүй амьд байцгаав.
Арам жадаар болшгүй болоод
Ажнай морины хурдаар ирээд
Арван хуруугаараа барилцаад авав.
Хүлэг мориных нь найман хөл
Хүрэлцэж солбилоод ирэв.
Хүчит хоёр баатар

Хүлэг мориноосоо холбирхгүй байв.

“Өвсөн хоолтой малыг зовоохгүй

Өөрийн биеэр үзэлцье.

Аав ээжийн өгсөн

Алд биеэр үзэлцье” гээд

Хоёр хүлгээ сойгоод орхив.

Хоёр баатар тулаад ирэв.

Тахийн арьсан өмдийг

Тахим дээрээ шуугаад

Бугын арьсан шалбуурыг

Булчин дээрээ эвхээд

Үүдэн энтэй нумаа атгаад

Үзүүр сайтай сумаа онилоод

Үзэлцэх гээд зогсож байв.

Тэнгэрийн Төгөө Бүс хэлэн байна:

“Халдаж ирсэн чи харвах уу?

Халдуулж байгаа би харвах уу?” гэв.

“Халдаж ирснээрээ би

Харвай” гэж Хонгор хэлэв.

Өмнөөс нь нэг харвав.

Оргөн цагаан цээжинд нь тусав.

Хар болд үзүүр нь

Халтирч шантраад унав.

Тэнгэрийн Төгөө Бүс

Харвах болж байна.

Түүний харвасан сум нь

Түг хийж тусаад

Дөрвөн хуруу шантраад унав.

Зэр зэвээр болшгүй болоод
Гараараа шүүрэлцээд
Буур шиг шүргэлдээд
Бух шиг мөргөлдөөд
Аван аван сэгсрэлцээд
Ачин ачин цохилцов.
Уул давуулж хаялцаад
Ус давуулж шидэлцээд байв.
Хонгорын бие нь газраас хөндийрч
Хоёр хөл нь тэнгэрт гараад ирэв.
Атаат Төгөө Бүс
Аваад цохих гэтэл
Араг Улаан Хонгор
Аргатай хүний үр болоод
Ар хөлийнхөө чигчийгээр тулгуурлаад
Дөрвөн өдөр, дөрвөн шөнө тогтоод байв.
Оцол хөх халзан нь
Осолтой болсныг мэдээд
Болдоор хийсэн богочоо эвдээд
Төмрөөр хийсэн тушаагаа тасдаад
Хүрэл мөнгөн амгайгаа тас хазаад
Хүрч ирээд хэлж байна:
“Ширхэгийн үр биш билүү чи!
Шилтэй Зандан хатнаас
Гарсан биш билүү чи!
Харцага ясаа хэмхэртэл тэмцэж
Хамаг биеэ няцартал ноцолдож
Далан хааны нутгийг

Дангаар оруулсан биш билүү чи!
Далай Жангартаяа
Дайснаас хамгаалах
Дах болсон биш билүү чи!
Дайвалзах цагт нь
Дархан хүлэг адил явсан биш билүү чи!
Идэр арван наймтайдаа
Их баатар болно гэж
Итгэгдэж алдаршсан биш билүү чи!
Ганц хүнд дийлдэв гэх
Гашуудалт муу нэрийг яана чи!
Гадаа хөдөө дайралдсан
Ганц хүнд дийлддэг юм бол
Бугуйл мөнгөн цулбуураа
Буруу талдаа унжуулаад
Бусдын моринд гүйцэгдэлгүй
Бумбын өндөр шар цоохор байшинд
Буцаж очно би.
Эхнэр авах гэж явсан
Эрэлхэг хүргэний морь
Эмээлтэйгээ хөглөөд ирэв гэж
Эзэн Жангарын нутагт хэлэлцэгдэх
Энэ муу нэрийг яана чи!
Агсарга улаан бүснээс нь бариад ав.
Ардаг шар тохойгий нь шүүрээд ав.
Аман хүзүүгий нь мушгиад дар!” гэж байна.
Араг Улаан Хонгорын
Арван хоёр сүврээ нь

Агзасхийж махилзаад
Арван цагаан хуруу нь
Алган дундаа хавиралдаад
Агсарга улаан бүснээс нь аваад
Ардаг шар тохойгий нь
Аман хүзүүнд нь нийлүүлээд дарав.
Хажиг шар тохой нь
Хар махы нь цоолоод
Хатуу ясанд нь хүрэв.
Нэг мушгиж дараад
Нэмж хоёр дараад
Нэтэрч гурав дараахад
Хоёр хөл нь газарт хүрэв.
Тэнгэрийн Төгөө Бүсийг
Тэвэрч аваад эргүүлдэв.
Тээглэсэн чулуунд хэв ортол нь цохив.
Араг Улаан Хонгор асууж байна:
“Залуу хүн гурван гомдолтой гэдэг.
Гомдлоо хэл
Голы чинь сугална би” гэхэд
“Над хэлэх гомдолгүй.
Намайг яхыг өөрөө мэд” гэв.
Хотолзох бэлхүүсээр нь тас цохиод
Хоёр хэсэг болгоод хаяв.
Асман хээрт нь
Алс хаяж ганзагалаад
Ардаа хөтлөөд давхив.
Замбал хааны цагаан өргөөний өмнө

Заан хоёр хүлгээ тавьж
Идэшлүүлж орхиод
Өнөөх хүүрийн зүлдийг аваад
Өргөөний баруун зүүн хоёрт нь
Өлгөөд орхив.
Алаг мөнгөн ширээний өмнө суугаад
Алтан дуулгаа дэр дээр тавив.
Зандан Гэрэл дагина тийш
Завдаж хараад хэлэн байна:
“Олон шөнө, олон өдөр явсаар
Оройн үс минь даахирав.
Дагина сайхан авхай минь
Дарвиж босож ирээд
Даахирсан гэзгийг минь
Дариухан самнаад өгөөч” гэв.
Гэтэл тэр хүүхэн
Гэдрэг ухарч
“Ширхэгийн уг удам
Шимэгдэж сөнөхийг хэзээ үзэх вэ?” гэж
Гараа нэг зангав.
“Заяаны янагаас минь
Зайлуулж хагацуулсан элмэр!
Эзгүй хээр
Ээрэм талд
Эргэх замаа мэдэхгүй
Элж үх чи
Хайртаас минь салгаж
Хагацуулсан элмэр чи

Хагсуугийн хар шилд
Хайш яиш явахаа мэдэхгүй
Хатаж үх чи” гэж
Бас нэг зангав. Тэгэхлээр
“Хайртай ханьтайгаа
Хамтдаа бай!” гэж хэлээд
Бэлхүүсээр нь тас цохиж унагаад
Баруун зүүн хатавчинд нь өлгөөд орхив.
Зүүн биед нь байсан арзнаас
Далан хүн дамжилдаг
Далгай шар шаазангаар
Дараагаар далан нэг
Даран уугаад орхив.
Босож ирээд
Найман хөлтэй
Нанжир мөнгөн ширээн дээр хэвтээд
Ариун ухаанаа тунгаагаад
Рашаан хар нулимсаа
Асгаад уйлж байна:
“Хариад гэртээ очвол
Хамаг сайчууд хорон үг хэлнэ.
Богд Жангар хааны
Болзож заасан хүүхнийг
Болдоггүй дайсан боловч
Боохолдой шулам боловч
Богтолж авчрах ёстой” гэж
Боорлож намайг зэмлэнэ.
Гэвч над шиг хүн

Гэндэж үхэхээс айхгүй.
Хараалч хүүхний үгээр
Хайран бие минь сөнөвч
Ард минь хишиг ихтэй
Алдарт Жангарын оронд
Азтай хөвгүүд олон төрнө” гээд
Ааг зоригтой босож ирээд
Асман хээрийг тас цавчаад
Ацтай modoор шорлож
Ассан галд шараад идэв.
За тэгээд шөнө болоход
Замбал хааны байдаг
Зандан байшинд хүрээд ирэв.
Арван хоёр цонхы нь балба цохиод
Алтан ширээн дээр байсан Замбал хааныг
Азай буурал үснээс нь
Атгаж аваад чирэв
Ууц нуруунаас нь
Ург сур гурвыг зүсэж аваад
Бүхэл биеэс нь
Бүтэн сур дөрвийг зүсэж аваад
Дарвайсан шарх дундуур нь
Далан гурав ташуурдаад
Ширээний нь зүг
Шидээд орхив.
Оцол хөх халzan дээрээ мордоод
Орон нутгаа чиглээд давхив.

* * *



Өдрийн нарны доогуур чиглээд
Өөрийн нутаг орныг зүглээд
Оцол хөх халзныхаа олмыг чангалаад
Онц сайхан хурдаар нь давхиад байв.
Тууш гурван сарын газарт
Тун зогсолгүй давхив.
Оцол хөх халзан нь
Махандаа өөхгүй болж
Мацах чадлаа барав.
Ясандаа чөмөггүй болж
Ягтаа тулж эцэв.
Соотон хоёр чих нь дэлдийв.
Соргог хар нүд нь балайрав.
Газрын холд төөрч
Ган халуунд цангаж
Араа хавишуулах өвс олдохгүй
Ам зайлах ус олдохгүй болоход
Ар бие нь наранд шарагдаад

Өмнө бие нь салхинд цохигдоод
Урт шар цоохор жадаа
Урдаа хөндлөн дүүрээд
Ухаан сэхээгээ алдаад ирэв.
Унасан хүлэг морь нь
Бэрхийн Хар шилд ирээд
Бэрэвхий дөрвөн хөлөө жийгээд
Бэтэг өвсний толгойг үмхээд унав.
Хүлэг морь нь тэрийгээд хэвтэв.
Хүчит Хонгор ухаангүй ойчив.
Хүн морь хоёул
Дөрөв хоног ухаангүй хэвтэв.
Дөнгөж амьсгаатай байв.
Гулдайж хэвтсэн тэр хоёрыг
Гурван хун нисэж ирээд үзэв:
“Энэ юун хүн морь хоёр вэ?
Энд ямар учраас хэвтэж байна?
Хойдын буян болог.
Хоёр амьтанд унд өгье” гээд
Аманд нь юм хийж өгөөд
Агаар тэнгэрт нисээд явчив.
Араг Улаан Хонгор
Амь орж босов.
Агт морь нь бас сэргэв.
Хүчит Хонгор босоод
Хүлэг мориндоо мордож
Алс гурван сарын газарт
Амралгүй давхив.

Унасан морь нь бас
Урьд мэтээр эцээд
Махандаа өөхгүй
Ясандaa чөмөггүй болж
Арай ядан
Алхалж явтал нь
Өмнө биед нь
Ерэн есөн жад залгасан мэт өндөр
Ирмэг эгц эрэгтэй
Их Ганга мөнгөн далай дайралдав.
Ирмуун их долгион нь
Илдийн ир шиг харагдav.
Үелзсэн ширүүн урсгалд нь
Ухрийн чинээ чулуунууд
Үйрч хэмхэрч унаад байв.
Усан дотор чулуу хагарахад
Улаан гал улсхийж байв.
Уруудас гээд
Усны хөвөөгөөр явж байтал
Гэнэт хөх дэнжийн өвс
Хүйтэн булгийн ус тааралдав.
Бууж ирээд
Булгийн эхэнд морио тавив.
Гал үд болоход
Хатгах жадаа бариад
Далайн эрэг дээр гараад
Давалгаат усыг харж байтал
Усан дотор тул загас

Умбаж явах нь харагдав.
Аман хүзүүгээр нь
Алтан шар цоохор
Арам жадаар хатгав.
Шархтай тул
Шарваж туйлаад
Шаасан жадтай нь Хонгорыг
Шаагисан далайд хаяв.
Шал хийх чимээгий нь
Сайн хүлэг нь сонсоод
Сандран хүрч очоод
Наян найман алд сүүлээ
Намируулан хаяж өгөөд
“Арам жадаа аваад
Амь гарахыг бод” гэж
Ачит морь нь хэлэв.
“Базсан армаа ч тавихгүй
Барьсан загасаа ч алдахгүй” гэж
Баатар Хонгор бархирав.
Эрхэм сайн хүлэг нь
Энэ үгийг сонсоод
Сулдсан хөлөө чангариуулж
Сугандаа хүртлээ газарт шигтгэн
Суга татаад авав.
Загас жад хүн гурвуул
Залгаа залгаагаар гараад ирэв.
Загасыг гаргаж ирээд
Зад татаад шарж идэв.

Мянган өрхийн үнэтэй
Мяндсан цагаан цачраа бариад
Сур мэт сунаад
Сухай мэт улайгаад унтав.
Долоон долоо
Дөчин есөн хоног
Дороо хөдлөлгүй унтав.
Оцол хөх халзан нь
Ортог дээр нь ирж тургиад сэрээв.
Ойртоод морио харсан чинь
Оцол хөх халзан нь
Сая бэлчээрээс барьсан юм шиг
Сайхан таргалсан байв.
Сэгсийсэн үсээ илж самнаад
Сэргэсэн биеэ засаж залаад
Сэвэрсэн загасаа шарж идээд
Сэруүн булгийн усыг уугаад
Оцол хөх халзандaa мордоод
Орон нутгаа чиглээд
Ганга мөнгөн далайн
Гаталгаар дайран оров.
Долоохон хоногийн хугацаанд
Довтлон гатлаад гарав.
Уснаас гараад гурван сар давхив.
Урьдын адил морь нь эцэв.
Арай гэж ядарч
Алхалж гэлдэрч явтал
Өл Манхан цагаан уул нь

Өндөрлөж харагдаад ирэв.
Дэргэд нь хүрч очив.
Дээр нь арай ядан гарав.
Оцол хөх халзнаа сойж орхиод
Уялга мөнгөн цулбуурыг сунгаад
Урт хар ташуураа түшээд
Хавь ойрын газрыг
Хар нүдээрээ ажиглав.
Үдийн нарны зүгт
Үүл шиг хүрэл байшин
Үлээсэн галын оч мэт
Үзэгдэж байв гэнэ.
“Эзэн Жангарын байшинаас
Энэ юугаар ялгаатай вэ?” гээд
Ахиж шинжлэн харахад
Алд хэрийн өргөн болоод
Арван хуруу өндөр байв.
“Бас дөрвөн тивийг эзэлсэн
Баян их хааны
Байшин биз” гэж санаад
Бараа нь харагдах боловч
Бас очиход хол юм
Бараалхаж очиход хэцүү” гэж
Бараан хар нулимсаа унагаж уйлав.
Баатар биеэ хувилгаж
Байдал учрыг мэдье гэж бодоод

Оцол хөх халзнаа
Олиггүй муу даага болгоод
Өөрийн бие нь
Оройгоос нь маажихад
Арван ёт унам
Тархинаас нь маажихад
Таван ёт унам
Тархай хожгор хөвгүүн болоод
Даагаа унаад
Дав дав гээд
Байшинг зорин хүрэв.
Дав дав гэж явсаар
Хүрэл мөнгөн байшинд
Хүрээд очив гэнэ.
Олон түмэн цахар нь⁸
Оруулахгүй хөөв.
Аргагүй болоод ирэхлээр
Аргалын дэргэд буугаад хэвтэв.

* * *

Тахимдуу цахрын дотроос
Тарган улаан шард
Татаар тэрэг хөллөсөн
Тагжгар өвгөн хүрч ирээд
“Энэ юун даага, хүү хоёр
Энд хэвтэж байгаа юм?” гээд

8. Хааны орд өргөөний хавийн шадар албат харьяат нарыг
цахар гэдэг байсан

Эгцэлж очих гэтэл
Өмхийд нь тэсэж ядаад
Өөр тийшээ явав.
Буцаж урцдаа ирэхэд нь
Буурал эмгэн нь асуув:
“Тэрэг чинь яагаад хоосон байна?
Тээсэн аргал чинь явав?” гэв.
“Эцсэн бор даага
Элсэн хөвгүүн хоёр хэвтэнэ.
Бузар өмхийд нь очиж чадалгүй
Буцаад ирэв” гэж гэнэ.
“Эртнээс нааш чи дандаа
Эндүү ажил хийдэг шүү.
Тэнэг чи бид хоёрт
Тэврэх үр байхгүй шүү.
Тэнгэрийн өгсөн хөвгүүнийг
Тэнд яагаад орхив чи?
Тэр хөвгүүнийг үтэр авч ир!” гээд
Хар төмөр шилээврээр
Халzan толгойгий нь хатгаж хөөв.
Өвгөн шараа хөллөөд
Өнөөх аргалдаа явав.
Өвгөнийг эмгэн нь дуудаж
Өмгөр хувинтай усыг дүүжилж өгөөд
“Өлсөж ундаассан юм байлгүй
Өвгөн чи ус өг” гээд явуулав.
Өвгөн хүрч очоод
Хөндийхөн газар зогсоод

“Хөвгүүн чи амьд юм бол
Хөнөгтэй усыг уугаач.
Хөсөг тэргэндээ чамайг ачаад
Хөгшин эмгэндээ аваачиж өгье” гэв.
Араг Улаан Хонгор
Аргатай юм болоод өндийж босоод
Усны хагасыг өөрөө уугаад
Үлдсэн хагасыг даагандаа өгөөд
Амь ороод сэргэцгээв.
Аргалын дотроос гараад ирэв.
Өвгөн аргалаа ачаад
Өнөөх хүүг даагы нь унуулаад
Өөрийн гэрт дагуулаад ирэв.
Өмнөөс нь эмгэн гарч ирээд
Өрвөгөр хүүг дааганаас нь буулгаад
Өөрийн хүүхэд шиг тэврээд авав.
Хар урцандаа оруулаад
Хамаг хирийг угааж цэвэрлэв.
Өвгөн даахитай даагы нь хөтлөөд
Нуурын уснаас усалж
Нугын ногоонд тавив.
Тархай хожгор хүүг
Таалж баршгүй сайхан
Танхил хүү болгоод авав.
Нэлээд хоносны хойно
Нэг өдөр хааны хүү
Ахлагч түшмэлийн хүүхдүүдтэй

Аргай⁹ шагай хоёрыг
Авалцан шагалцаж байх нь үзэгдэв.
Нэг түшмэлийнх нь хүү хэлж байна:
“Тархай хожгор хүү
Та бидэнтэй шагалцахаар айсуй” гэхэд
Хааны хүү зарлиг болов:
“Залуу хүнийг найрт наадна гэхэд
Зайлзуулж хорих ёс байхгүй” гэв.
Тархай хүү ойртоод ирэв.
Түшмэлийн хүү асууж байна:
“Тархай! Бидэнтэй шагалцахаар ирэв үү чи?” гэхэд
“Та нар зөвшөөрвөл
Тавтай наадах санаатай би” гэв.
“Хүүдийтэй алтаар мөрий тавьдаг
Хүүхэд бидний наадамд
Хүү чи юугаа тавих вэ?” гэхэд
“Боломжтой гэж та нар зөвшөөрвөл
Бордсон шараа нэгд тавина.
Бор даагаа хоёрт тавина.
Болохгүй бол тэгээд
Бойжуулсан аав ээж хоёрыгоо
Бооцоонд нэмээд тавина” гэв.
“Мөрийгий нь их бага гэлгүй оролцуул.
Мөчий нь урт богино гэлгүй тоглуул” гэж
Хааны хүү зарлиг болгов.
Бай тавих хоёр аргайг
Барьж харвах хоёр шагайн хамт

9. Аргай гэж том амьтны шагайн нэр.

Бас түүнд өгөв.
Түрүүлж гараад
Түшмэлийн хүү харваж алдav.
Түүний дараа шинэ хүүг
“Түргэн харва!” гэхэд хүү харвав.
Нэг шагайг давуулаад алдav.
Нөгөө шагай нь тов гээд онов.
Дараа нь харvasан шагай
Тас гээд бас онов.
Бооцонд авсан юмаа
Боогоод авав.
Боолтон дотор нь
Болгомол алт гурван тулам байлаа.
Нэхэж бас тоглоод
Нэг тулам алтаа алдav.
Хоёр тулам алтаа
Хос ханцуйдаа хийж
Холбож үүрээд гэртээ ирэв.
Авч ирсэн юмаа
Аав ээж хоёрынхoo
Авдрын өмнө тавив.
Аав ээж хоёр нь
Амь тэжээх дөрвөн хошуу мал¹⁰
Аливаа зүйлийг арилжиж аваад
Айлын хүнээс юм горьмооргүй
Ах дүүгээс хoormog гуймааргүй болж
Аргагүй сайхан амьдрах болжээ.

10. Дөрвөн хошуу мал гэдэгт адuu, хонь, үхэр, тэмээ орно.

* * *

Өдий төдий хоног өнгөрөв
Өнөөх хааныд нэг өдөр
Хулс мэт олон хүн цуглуулаад
Хурим найр болоод байв.
Тархай гэртээ орж ирээд ааваасаа асуув:
“Хаан эзний өргөөнд
Хамаг амьтан цуглаад
Хулс мэт олон хүн
Хурим хийж байх бололтой” гэв.
“Хүү минь энэ чинь
Дөрвөн тивийн нэгийг эзэлсэн
Догшин Цагаан Зул гэдэг хаан.
Тэдний долоон настай
Гэрэнзэл гэдэг хүүхэнд сүй тавьсан
Манхан богдын ач
Малаа Цагаан гэдэг бөх
Хамгаалах таван зуун нөхөдтэйгөө
Хамт хүрч ирээд
Хааяа хааяа найр хийдэг юм.
Хүүхнийг өгөвч авна.
Эс өгөвч авна гэдэг юм.
Хүүхэн очно ч гэдэггүй
Очихгүй ч гэдэггүй юм” гэв.
Энэ үгийг ааваасаан сонсоод
Эзэн хааны оршдог
Шил гарди байшин руу нь ширтэж харав:
Гунхсан сайхан Гэрэнзэл хүүхэн



Гучин зургаан цонхоор
Нарны гэрэл гаргаж суух нь харагдав.
Бас нэлээд хоносны хойно
Нуурын хөвөөнд байсан
Бор даагаа харчихаад буцаж явав.
Шил гарди байшингаас
Шинжээч цагаан хүүхэн гараад
Эрвэн сайхан нөмрөгөө дэрвүүлээд
Эгц биений нь чиглээд айсуй.
Зөрөөдөн өнгөрөх гэтэл эргээд
Түрүүлээд явах гэтэл дагаад
Ангар ангар инээсээр хүрч ирээд
“Ах ноён та
Амар мэнд ирэв үү?” гэж асуув.
Тархай хэлэн байна:
“Налайж сууж таргалсан охин
Надаар битгий доог болго!

Наадах дооглох хэрэгтэй бол
Цахар борчуулын хүүхэд
Цаана чинь олон байна” гэхэд
Хүүхэн хэлэн байна:
“Таныг би таньж байна.
Тансаг Бумбын орны хүн шүү.
Наран гараах ар биеэс
Нааш морилж ирсэн
Үйзэн алдар хааны үр
Үеийн ганц Жангарын нутгаас
Таныг ирснийг мэдэж байна би.
Бөх Мөнгөн Шигшрэгийн ууган хүү
Шилтэй Зандан Гэрэл хатнаас гарсан
Арслангийн Араг Улаан Хонгор гэж
Таныг таньж байна би.
Манай хааны хүүхэн
Мэндий тань мэдээд ир гэв.
Түүнээс илүү юм ярилцах ёсгүй” гэв.
Эрвэн сайхан нөмрөгөө дэрвүүлээд
хүүхэн явчив.
Энэ үгийг нь сонсоод хүү
Эргэж хариад
Оцол хөх халзандаа хэлэв:
“Сая чамайгаа харчихаад буцаж явтал
Санамсаргүй нэг хүүхэн хүрч ирээд
Савсаг янзын үгийг хэлээд
Салаад явчлаа.
Яаж байвал дээр вэ?” гэж

Яарч мориноосоо асуув.
Хөх халzan нь хэлэн байна:
“Сүргээс салсан гөрөөс
Аймтгай гэдэг эс билүү?
Биеэ дарж
Билгээ тодруулж бай.
Сонин үг чамд өдөр бүр
Сонстоно гэсэн нь энэ” гэв.
Ууль хар урцдаа гүйж ирээд
Аав ээж хоёрынхoo өвөрт ороод унтаv.
Өдий төдий хоног
Өнгөрсөн хойно нэг үдэш
Өөрийнхөө даагыг хараад
Өвгөнийдөө харьж явах үед
Эрвэн сайхан нөмрөгөө дэрвүүлээд
Эртний уулзсан цагаан хүүхэн
Элэгсэг янзаар ирээд хэлэв:
“Аав хааны авхай таныг
Аав ээжээ унтуулаад
Алтан шил гарди байшинд минь ир гэж
Авхай Гэрэнзэл урьсан” гэв.
Хамаг амьтан унтахын үед
Хар эсгий хэвнэгээ нөмрөөд
Хааны шилэн байшинд хүрээд ирэв.
Ухас гээд үүдий нь татаад ороход нь
Урт цагаан мөнгөн ширээн дээрээ
Ухаант хүүхэн хоёр дахь нарны гэрэл гарган сууна.
Ороод ирэхэд нь босож ирээд Тархайг

Орныхоо өмнө байгаа
Олбог дээр суулгав.
Мэндий нь асуугаад
Мэхэсхийж ёслоод
Өөрийнхөө гансанд тамхи нэрж өгөөд
Өндөр суудлын нь дэргэд
Өөрөө очиж суув.

Хүүхэн хэлэн байна:
“Залуу бага насандаа та
Замбал хааны охин Зандан Гэрэл хүүхэнд
Заяаны сүйг тавиац явснаа санана уу?
Тэр хүүхний хараалаар та
Тэнэж үхэх шахсанаа санана уу?
Уул нутагтгаа буцах замдаа
Урт гурван сарын турш
Ус ундгүй цангаж байхад тань
Хун шувуу болж хувилаад би
Хурамхан зуур хүрч очоод
Гандсан хувхай газраас зайлцуулж
Ганга мөрний эрэг дээр аваачлаа.
Хүлэг моринд тань өл болсон
Хөх дэнжийн өвс бол
Хөхөл үсний минь сэв билээ.
Хүдэр биед тань унд болсон
Хүйтэн булгийн ус бол
Хүүхэн миний нулимс билээ.
Мөрөн далайгаас хөшиж гаргасан
Мөнгөн сайхан загас бол

Мөн миний махбод билээ.
Элдэв зүйлээр хувилж
Эрхэм тандаа тус хүргэж явлаа.
Хүүхэн миний дөрвөн настайгаас эхлээд
Хүргэн болох сүй тавьсан хүн
Хүрч ирээд байна” гэв.
“Өдий хол газраас
Эндүүрэлгүй мэдсэн юм бол
Эрт яагаад нааш ир гэсэнгүй вэ?” гэж
Хонгор уурлаж хэлэв.
“Тэгэхлээр урьд мэт болж
Уг биеэ үзүүлэгтүн” гэж хүүхэн хэлэв.
Араг Улаан Хонгор
Агаар тэнгэрт мандсан
Арван тавны сар мэт
Алтан ширээн дээр
Асар сайхан дүнхийж суув.
Үдшийн шөнөдөө найрлав.
Үүр цайтал наадав.
Өглөө эртлэн босоод
Өнөөх Тархай хэвээр болон
Өвгөн аав ээж хоёрынхoo
Өвөрт нь ороод унтав.
Нэлээд хоносны хойно
Нэг орой даагаа хараад харьж явтал
Урьд уулзсан цагаан хүүхэн
Угтаж гүйгээд ирэв.
“Хааны авхай таныг

Харанхуй болоход ир” гэв.
Манхан богдын ач
Малаа Цагаан гэдэг бөх
Таван зуун нөхдөө дагуулаад
Тавтай найрлахаар ирсэн байна.
Таныг “Жангар” хэлэгтүн гэв.
Ар талынхнаа магтаж
Алдарт “Жангар”-ыг дуул гэсэн” гэв.
Аав ээж хоёроо унтуулаад
Арьсан хэвнэгээ нөмрөөд
Алхалж очив хүү.
Байшингийн нэг буланд
Багтаж ороод суув.
Хааны хүүхэн хүргэн хоёр
“Жангар” хэлүүлэх хүүг олоод харав.
Жангарч хүүг уриад
Жаргалын найрт дагуулж оров.
Баруун биед нь хүргэн хүү
Баяртай таван зуун нөхдөө дагуулаад сууна.
Зүүн биед нь хааны хүүхэн
Зүрхний найз турван зуун хүүхэнтэйгээ сууна.
Гаднаас ирсэн Жангарч хүүг
Гар угаадаг ширээн дээр суулгав.
Гуулин цөгцтэй архиар
Гурван удаа хүндлэв.
“Хөвгүүн “Жангар” хэлэгтүн” гэв.
“Эртний эхэн цагт
Энэ олон бурхдын шажин тогтох цагт гарсан

Тахь Зул хааны үлдэл
Тансаг Бумба хааны ач
Үйзэн Алдар хааны хөвгүүн
Үеийн өнчин Жангар билээ.
Долоон настайдаа
Доордын долоо хортныг доройтуулаад
Дуутай Жангар цолоо дуудуулсан.
Эрхэн шарын зургаан мянган
Арван хоёр баатруудаас
Эрхэм шилдэг нь гэвэл
Бөх Мөнгөн Шигшрэгийн ууган хөвгүүн
Шилтэй Зандан хатны
Хорин хоёртойд нь төрсөн
Төр шажин хоёры нь
Гар дээр нь авч өгсөн
Арслангийн Араг Улаан Хонгор болно” гээд ирэхээр
Ажиггүй ярих аргагүй болоод
“Энэ их баатар
Эдүгээ цагийн хүн болоод
Энд ирвэл та нар яана!” гээд
Хамаг олны дунд
Хашхирч орхив.
Хашхирсан их дуунд нь
Хааны шил гарди байшин дайвалзав.
Хаахирсан дуунд нь сүрээ нэмэх гээд
Хааны хүүхэн Тархай хүүгийн хормойноос
Хадсан хоёр гадсыг
Хамх цохиод хаяв.

Маргааш болтол нь “Жангар” хэлүүлээд
Мянган шар толгойтой хонь
“Жангарын” шанд өгч туулгаад явуулав.
Хонгор хүү хонио авч ирээд
Хар урцныхаа өмнө¹
Хашиж хэвтүүлэв.
Нэлээд хоносны хойно
Нэг үдэш даагаа хараад
Өөрийн гэрт буцаж явтал
Өнөөх шинжээч цагаан хүүхэн
Өөдөөс нь гүйж ирээд хэлэв:
“Өнөө орой
Өвгөн хааны хүүхэн хүргэн хоёр
Өөр өөрийн бөхийг
Өргөөний өмнө барилдуулах юм гэнэ.
Оршөөлт авхай таныг
Өөрийн бөх гэж барилдуулах гэнэ.
Өрсөгч бөхийг хаяхаас биш
Өөр зан хэрэггүй” гээд явчив.
Тархай хөвгүүн гүйж ирээд
Тавилант аав ээжээ унтуулаад
Тансаг шилэн байшинд нь хүрээд ирэв.
Хааны хүргэн, хүүхэн хоёр
Сарын саруулд
Гадаа гарч ирээд суув.
Бөхөө барилдуулья гэж ярилцаад
Таван зуун хүүхэн
Тархайг зодоглож

Ногоон тортон хөшигний цаана зогсоов.
Цаадах хүргэн нь их хар бөхөө зодоглож
Цагаан хөшигний цаана зогсоов.
Талбай дунд хөшиг нээхэд
Нэг нь тохойн чинээн Тархай болоод
Нэг нь том хар бөх зогсож байв.
Том хар бөх
Тонгойж Тархайг хараад
“Навтгар энэ юмтай
Намайг барилдуулах юм уу?” гэж гайхав.
Тархай хэлэн байна:
“Ялж унагахад том жижиг нь
Ямар хамаа байх вэ!” гээд
Яндан шилбий нь
Хугартал ташив.
Янхигар биеий нь
Хэмхэртэл шидэв.
“Яасан хортой амьтан бэ? гээд
Ямбатай хүргэн тосоод барих гэв.
Хааны авхай завсарт нь ороод
Халгаж биед нь хүргэлгүй
Хайрт Тархайгаа аваад одов.
Маргааш өглөө нь болоход
Маргаанд дийлсэн Тархай хүүд
Мянган цагаан хонь шагнаж өгөөд
Мяндсан ноостой долоон цагаан тэмээнд
Оосор бүчгүй
Орд цагаан өргөөг ачаад өгөв.

Тамтаг болсон урцныхаа ойр ирээд
Тархай хүү аавдаа хэлж байна:
“Хоёр мянган хоньтой учраас
Холхон очиж нуурын хөвөөнд буяа.
Албат цахрын дотор
Аж төрөхөд хэцүү байна” гээд
Хулст нуурын хөвөөнд
Хун цагаан өргөөгөө бариад
Хуучин муу гэрээрээ
Хураасан аргалын гэр хийв.
Дараахи өглөө нь
Даргилсан цайгаа уугаад
Даагаа үзэхээр явж байтал
Ар Бумбын орон нь санагдаж
Аршаан хар нулимс нь гоожив.
Тэгж байтал нь
Шинжээч цагаан хүүхэн ирээд
“Таныг нааш ир гэнэ” гэв.
Дагуулж аваад явав.
Хааны авхай угтаж аваад
Хар архи гурван цөгцийг өгөв.
Хүүхэн хэлж байна:
“Дөрвөн настай байхад минь
Дөмнөж сүйлсэн хүргэн
Сайн үйлээ гүйцээгээд
Санасан хэргээ бүтээх гэж байна.
Саатуулах санаа танд үгүй юу?” гэв.
Ухасхийж хүү гараад

Оцол хөх халзандаа хүрээд ирэв.
“Ямар гэдэг газарт
Яаж байгаа минь энэ вэ?
Өл Манхан Цагаан уулыг
Өгсөж ирсэн биш билүү би?” гээд
Урагш хойш харахад нь
Уулан дээгүүр давсан
Улаан тоос харагдav.
“Энэ уйлсан нүд болоод
Эндүүрч байгаа болов уу?” гээд
Ахиад сайн харахад нь
Аранзал зээрдийн тоос мөн байв.
“Очоод уулзах уу? Яах вэ?” гэж бодоод
Оцол хөх халзныхаа
Онгон дэлийг тэврээд зогсов.
Шинжээч цагаан хүүхэн ирээд
“Нааш ир” гэж уриад
Дагуулаад явав.
Хааны хүүхэн утгаж
Хар архи гурван цөгцийг өгөөд
“Эрхэм баатар хүн
Эрж байж уулzsанаас
Эрүүлж байж уулзсан нь сайн биш үү?” гэхэд
Тэр үгий нь сонсон хариад
“Аав минь! Архаг бэтэгтэй билээ би.
Аргагүй өвдлөө” гээд хэвтэв.
Аав нь хөлий нь тэврэв.
Ээж нь толгойгий нь тэврэв.

Алдарт Жангарын
Ар бие нь наранд өгрөөд
Өвөр бие нь салхинд цохигдоод
Алтан шар цоохор
Армаа хөндлөн дүүрээд
Арай ядан ороод ирэв.
Аранзал зээрдийн
Арьсанд нь өөхгүй
Ясанд нь чөмөггүй болж эцсэн байв.

* * *

Хүрэл байшингийн үүдэнд
Хүрч ирээд
Хүдэр жадаа бөхийлгөж байгаад дуудав:
“Хүрээлсэн дайсны дотроос
Хүлэг морьтой минь шүүрээд авдаг
Хүчит элээ минь билээ
Шүргээд ирсэн дайсны дотроос
Шүүрээд авдаг начин минь билээ.
Өчүүхэн юманд
Өө санаад алга боллоо¹¹
Үзсэн далан хааны нутагт явж эрэв.
Үзээгүй хорин таван орноор эрээд ирэв.
Үнэнч баатар Хонгорын минь
Үзээд хэлж өгсөн хүнийг
Гэлэн бол

11. Хонгорын жинхэнэ явсан учрыг нууж ёстоор ярьж байна.

Бумба далайн хөвөөнд
Буман шавь суусан
Бурхны сүмийн тэргүүн лам болгоё.
Хүүхэн хүн бол
Арван зургаатай Шавдал хатныхаа
Адил жаргалтай байлгах билээ би
Залуу хүн бол
Энэ хааны нутгаар
Шан өгөөд хаан суулгах билээ би” гэсэнд
“Тэнэмэл хүн бидэнд үзэгдсэнгүй” гэж
Тэр догшин Цагаан хааны хэлэхийг сонсоод
Алдарт ноён Жангар уйлж байна.
“Ямар хүний үр вэ?
Ясан сайхан хүн бэ?
Ямар гүүний унага вэ?
Ясан сайхан морь вэ?” гээд
Хүн морь хоёрыг гайхаж
Хүрч ирж үзсэн хүний тоо
Долоон бумаас
Доошгүй болж
Олон түмэн хүн
Огт тасрахгүй цуглаж байв.
Хонгор аавдаа хэлэн байна:
“Хааны үүдэнд байгаа
Зээрд морьтой хүнд очоод
Таны эрсэн хүн
Манайд байна гэж
Хүрч хэлэгтүн” гэв.

“Үр ганц хүүгийнхээ
Үгийг дагаж яваад
Үхсэн ч гомдолгүй.
Үтэр хүрч очоод
Үгий нь хэл тэр хүнд” гэж эмгэн хэлэв.
Зарим хүнд чичигдэн
Зарим хүнд түлхэгдэн
Завсрыг орж яваад
Заасан хүнд хүрч
“Алдарт таны эрж яваа
Алга болсон хүн манайд байна” гэж өвгөн хэлэв.
Аранзал зээрд нь
Амаараа өвгөнийг шүүрч аваад
Алдарт Жангартай өгөв.
Хаан Жангартай өвгөнийг тэврээд
Хаана байгааг түүнээс асуув.
Хулст нуурын хөвөөнд байгаа
Хун цагаан өргөөнд хүрээд ирэв.
Улаан Хонгор баатар
Урьдын янзандaa ороод
Угтаж мордоод ирэв.
Оцол хөх халzan ч
Онц сайхан болоод хувилав.
Хонгор Жангартай хоёр
Ховх үсэрч мориноосоо буугаад
Хошуу нийлүүлэн тэврэлдэв.
Хоохой халаг болж уйлалдав.
Хойноос нь дагасан

Хошууч баатрууд нь
Холын газрыг сүрээр дарсаар
Ойрын газрыг тоосоор дарсаар
Хонгорын өргөөнд хүрээд ирэв.
Эн тэнгүүнд нь Бөх Мөнгөн Шигшрэг
Эрэлхэг гучин хоёр баатрын багтах
Эрдэнээр бүтээсэн гэр өргөөг
Эгэм дээрээ өргөөд ирэв.
Бүтэн долоо хоногийн турш
Бүгдээр нийлж найр хуримыг хийв.
Эзэн Жангар нь Хонгороос
“Энэ хааны нутагт чамд
Элдэв талаар тохирох
Ээлтэй хүүхэн байна уу?” гэж асуув.
“Элдэв талаар тохирох
Ээлтэй нэг хүүхэн
Энд бий гэж хүн ярьдаг” гэв.
Эрэлхэг гучин хоёр баатар нь
“Ээлтэй тэр хүүхнийг
Энэ хааныг өгөвч авна
Эс өгөвч авна” гэж хаахалзав.
Эзэн Жангар нь:
Минъян бид хоёр түрүүлээд явна.
Миний хойноос та нар яв.
Мялаах хуримлах юмаа аваад оч” гээд
Мяндсан жолоогоо сунгаж сайварлуулаад
Мянган өрх албатынх нь дундуур
Мяралзуулаад гараад ирэв.

Хоёр баатрыг хараад
Хол ойрын амьтан гайхаж дагав.
Бэр хүн үзэхлээрээ
Бэлийнхээ гурван товчийг султган дагав.
Хүүхэн хүн үзэхлээрээ
Хөхнийхөө гурван товчийг таслан дагав.
Эмгэн хүн үзэхлээрээ
Ээтгэр шанагаа
Эмтэртэл хаяд
“Ээ чааваас! Арван таван насандaa
Энэ хүнтэй уулзах минь яалаа!” гэж
Элгээ тэврэн дагав.
Түмэн хүн өмнөөс нь угтав.
Буман хүн араас нь дагав.
Бумбын орны Жангар Минъян хоёр
Бурханы нь өргөөг зөв эргээд
Буурал Цагаан хааны
Хүрэл байшингийн өмнө
Хүрч очоод
Гурван галбир зандан улиасанд морио уяд
Арван дөрвөн үүдий нь
Ангас ангас татаад
Арван тавны сар мэт мандаж ороод
Догшин Цагаан Зул хааны
Мэндий нь асуугаад суув.
Араас нь даган
Жангарын гучин хоёр баатар
Хуримынхаа юмтай ороод

Баруун биеэр нь суув.
Малаа Цагаан хүргэний эцэг
Манхан бодг хаан ч
Бас архи идээгээ тавиад суув.
Хэлмэрч Хээ Жилган гэдэг баатар
Зүүн талд нь
Зүрхэлж суусангүй
Баруун талд нь
Багтаж суусангүй
Үүдийн тэнд
Үтээрхэж суув.
Алдарт ноён Жангар нь
“Зүүн баруун хоёрын
Нэгэнд нь суугаач” гэв.
“Баруун биеэр суухад
Алдарт Жангарын
Таалах эсэх нь мэдэгдэхгүй байна
Зүүн биеэр суухад
Манхан бодгын
Таалах эсэх нь мэдэгдэхгүй байна” гээд
Мөн тэндээ суув.
Догшин Цагаан Зул хаан
“Маргаан тэмцээн хийлгэнэ би
Маргааныг авсан тэр хүн
Манай хүүхнийг авагтуун” гэв.
Хоёр хуримын архийг
Хослуулж ууцгаагаад
Хорз арзаар найр хийгээд сууцгаав.

Анхан түрүүний маргаанд
Арван таван бээрийн газарт
Агт морио уралдуулав.
Саналын буурал халзан хүлэг
Салж тасран таван бээрийн газарт
түрүүлж ирэв.

Хоёр дахь маргаанд нь
Сум харвах болсонд
Жангарын Мэргэн Эрх Хар гэдэг баатар нь
Болзсоноор нь оруулаад бодсоноор нь гаргаад
Атаяа маргааныг авав.
Бас өдрийн сайнд
Гурав дахь маргаан болоод
Гурван эгнээ болж суугаад
Хоёр хүргэнийг барилдуульяа гэж байна.
Богд Жангар зарлиг болон байна:
“Хүүхэд ноцолдохоор тэсэхгүй
Хүүчээд ордог нэг өвгөн байна.
Түүнийг дарж байх
Таван мянган мангасын хөвгүүн өгөгтүн” гэнэ.
Бөх Мөнгөн Шигшрэгийг
Хасаг төмөр тэргэнд хүлээд
Таван мянган мангасын хөвгүүдээр даруулаад
Хоёр хүргэнийг тайчаад ноцолдуулав.
Хонгорыг доройтуулаад
Цаадах хүргэн нь аван алдаад ирэв.
Тэднийг харж байсан Мөнгөн Шигшрэг
Хасаг төмөр тэргий нь

Хамх цохиж хаяад
Таван мянган хөвгүүдийг
Тас үсэргэж хаяад
Малаа Цагааныг барьж аваад
Гар хөлий нь хугалаад
Газарт шигдтэл хаяад орхив.
Гарамгай Хонгор тэгэхлээр
Гадар махы нь огтчоод
Ганга мөрөн далайд хаяад орхив.

Манхан богд хаан хэлэн байна:
“Богд Жангар таны хишиг илүү сайн байна.
Огторгуйн дунд нар болсон
Одны дунд сар болсон
Онц хайртай үр минь унав” гээд
Таван зуун залуугаа дагуулаад харив.
Дараа нь
Өдрийн сайныг ончлоод
Сарын сайныг сахиад
Тал дунд нь
Жаран цагаан өргөө бариад
Гэрэнзэл хүүхнийг буулгаад авав.
Долоон долоо
Дөчин есөн хоногт найр наадам хийв.
Догшин Цагаан Зул хүүхнээсээ
“Надаас ямар инжийг авах вэ?” гэж асуув.
“Миний хүссэнийг өгөх бол
Нэг жилийн төлөө надад өгөгтүн!” гэв.
Хаан тэр үгийг сонсоод

Хамаг олон сайдуудтайгаа ярилцаад
Нэг жилийн төл гэсэн үг нь
Нэн сайн бодвол биднийг
Богд Жангарын албат
Бол гэсэн үг бололтой” гээд
Нутагтаа зар тавиад нүүв.
Эзэн богд Жангар
Орчлонгийн сайхан Минъян, Санал хоёрыг
“Есөн сарын газрыг
Ес хоноод хүрч
Нутагтаа мэдээ хүргэгтүн” гээд явуулав.
“Араас нь есөн сарын газрыг
Арав хоноод хүрье” гэж
Богд Жангар хаан
Гучин хоёр баатартайгаа залрав.
Хонгорын хатан Гэрэнзэл
Шар толгойтой хун болж хувилаад
Араас нь нисэв.
Гурван хоногийн өмнө ирсэн
Минъян Санал хоёр
Шихэр далайн хөвөөнд
Шигшрэгийн өргөөний ард
Дөчин дөрвөн ханатай
Дөрвөн мянган унтай
Барсын арьсаар дээвэрлэсэн
Бумбын цагаан өргөө босгуулаад
Нутаг албатаа цуглуулав.
Эзэн ноён Жангар тэргүүтэй

Гучин хоёр баатар залраад ирэв.
Бууж ороод долоон тойрог болж суув.
Эмнэг гүүдийн сүү
Элбэг арзын суурь болоод
Долоон долоо
Дөчин есөн хоногт
Найр наадам болов.
Найрын сүүлд нь богд Жангэр
Бадмын сайхан ерөөлөө тавиад мордов.
Ард нь сайдуудын найр тарсан цагт
Шилтэй Зандан Гэрэл хатан
Таван сарын газарт
Арай багтмаар буурилсан албатыг
Зүс зүсээр нь тоолж
Хонгорын гэрт оруулж үзүүлээд
Бурхны шажин нь нарны гэрэл мэт мандаад
Ертөнцийн төр нь хад мэт батжаад
Жаргаж наргиж суудаг болов.



БУУРАЛ ХАЛЗАН МОРЬТОЙ БУЛИНГАРЫН ХӨВГҮҮН ДОГШИН ХАР САНАЛЫН БҮЛЭГ

Долоон тойрог болоод
Догшин хар арзыг зооглоод сууж байтал
Эзэн Жангар зарлиг болов:
“Булингарын Догшин хар Санал минь
Чамайгаа нэг харь газарт явуулах гэж байна би.
Хүдэр Заарын Заан тайж хаанд
Ээл /найрамдах/ болбол ээлий нь сонсоод
Эргэж хурдан ир” гэв.
Санал босоод алтан дуулгаа аваад
Алдарт Жангартaa гурав мөргөн

Аршаан хар нулимсаа асган хэлж байна:
“Буян төгс ааваа буянгүй орхиод
Бурхан сайхан ээжээ хөвгүүнгүй орхиод
Буман өрх албатаа ноёнгүй орхиод
Булбарай сайхан хатнаа ганц биеэр хаяд
Буурал халзнаараа ирж таныг дагасан билээ.
Алс харь газарт очихлоор
Ард минь үлдэх
Ах дүүгийн оронцог үгүй л.
Харь газарт явахлаар
Халуун тогоо хоол өгдөг
Хамаатан садны оронцог үгүй л.
Адгийн надаас илүү
Арслан чийргүүд олон байна л.
Алс газарт өөр хүнийг явуул” гэж
Алаг нүднээсээ нулимс гаргаж
Алтан ширээнээс нь адис аваад суув.
Алдарт богд Жангар нь
Арван цагаан хуруугаараа
Алд хар үсээ хойш нь илээд
Айлдаж хэлэв түүнд
Ганц бие гэж чамайг
Гадуурхаж байгаа юм биш.
Олон өнөр гэж би
Ондоо хүнийг явуулах аргагүй.
Миний үгийг хэлээд
Түүний хариуг сонсоод ир.
Ээлтэй байя гэвэл

Эсэргэн таван жилийн татвараа өг.
Мянга нэг жилийн албаа
Мятралгүй хүргэж ир.
Бумбын их орны
Булан хэсэг бол гэж хэл.
Халдах дайсан болно гэвэл
Хар цоохор тугий нь
Хага татаж ураад
Найман түмэн хар халзан агты нь
Над хөөж ирээч” гэв.
Санал буцаж сууриндаа суув.
Алдарт Жангар зарлиг болов:
“Аливаа зүйлийг
Алдалгүй мэддэг
Алтан Цээж минь
Айлдаж хэл.
Хүдэр Заарын Заан тайж хааны нутгийг
Хүрэх зам аль хэр хол бэ?
Хүлэг мориор хэд хоног явах вэ?
Хүрэх элчид тайлбарлаж өг” гэв.
“Наран суухын зүүн өмнө
Наадах өнцөг дор байх юм.
Сайр зоондоо таргатай
Сарьсан сугандaa өөхтэй
Гунан шар цоохор итлэг /начин/
Гурав өндөглөөд, гурав гуужаад
Хүрнэ үү? үгүй юу? гэх газар юм.
Хүлэг морь дөчин есөн сард давхиад

Хүрэх, эсэх нь мэдэгдэхгүй газар юм.
Хүдэр Заарын Заан тайж хаантан
Хүчит арзын суурь болоод
Түмэн цагаан баатартайгаа
Түйвээх хэлэлцээг хийж байна.
“Урагшаа гурван тивийн орныг эзэлсэн билээ бид.
Удаа дахь дөрөвдүгээр тивийн эзэн Жангарын нутаг
Улаан наран гарах зүгт байна.
Уулгалж түүнийг эзэлье” гэж байна” гэв.
Дайчин Санал босоод
Дарс архийг аваад
Далан хүн дамжилдаг
Далгай шар шаазангаар
Дараагаар далан нэг уув.
Амин улаан зүрх нь
Аюулхайгий нь гүвдээд
Арван хоёр сүврээ нь
Атис матис хийгээд
Арван цагаан хуруу нь
Алган дотроо үймэлдээд ирэв.
“Алтан дэлхийд хэвтэх
Алд бие биш үү.
Атга шороо дэвтээх
Аяга цус биш үү.
Амь алдавч
Айх юмгүй” гэж бодож суув.
Баруун биеэс нь
Баян Хүнхээн Алтан Цээж хэлэн байна:

“Харь газарт хүрч очоод
Хатуу үйлийг бүтээж чадах
Сайн хөвгүүн гэж
Саналыг би боддог.
Багцаалж мэдэхдээ надаас дутахгүй
Балтаар цавчихдаа Савараас дутахгүй
Баатар зоригоороо Хонгороос дутахгүй
Бахтай сайхнаараа Минъяанаас дутахгүй.
Ерэн есөн эрдэм төгссөн
Идтэй сайн хөвгүүн гэж
Ингэж би санадаг” гэв.
Арзаа уусан Саналын
Гадар бие нь улайгаад
Дотор бие нь халаад ирэв.
Алаг нүдээ
Арван хоёр эргэлдүүлээд
“Алдарт Жангарын зарлигаар мордоно би.
Ажнай буурал халзныг минь
Авчраад эмээллээ гэж хашхирав.
Хүдэр хар морьч нь
Хүний хэнхдэгийн чинээн
Хүрэл мөнгөн зуузайтай
Хүрэн суран хазаары нь
Хүвж шүүрч аваад гарав.
Хүлэг морьдын сүрэгт
Хөх дэнжийн өвсөнд
Хүйтэн булгийн усанд бэлчиж явсан
Буурал халзныг барьж аваад

Бумбын шар цоохор байшинг зөв эргүүлээд
Хаш мөнгөн үүдэнд аваад ирэв.
Болдын сайнаар богочлоод
Төмрийн сайнаар тушаад
Тансаг мөнгөн цулбуураас нь
Тавин сайн хөвгүүдээр бариулаад зогсоов.
Зулмал нимгэн зөөлөвчөөр нь жийрэглээд
Зургаан давхар тохмы нь тавиад
Дөш хар эмээлий нь тохоод
Дөрвөлжин цоохор олонцгий нь дэвсээд
Дөчин дөрвөн олмын
Наян найман горхиор
Арьсы нь атиртал
Шүүсий нь шүүртэл татав.
Зурааны эхэнд байдаг
Зуун найман хонхы нь зүүгээд жингэнүүлэв.
Хүзүүний дор байдаг
Хүрэл найман хонхы нь зүүгээд жингэнүүлэв.
Хурдан биеэ
Ялман сайхан хaa дээрээ хураагаад
Хурц биеэ
Хоёр нүдэн дээрээ хураагаад
Зургаан төө чихээ хайчилж
Зуур зуур солбиулаад
Өрмийн иш соёогоороо
Хүрэл мөнгөн зуузайг хавираад
Сагсгар сайхан хөхлөөрөө
Сар нартай наадаад

Сагаг дөрвөн туурайгаараа
Самуун орныг гишгэм болоод
Тансаг мөнгөн цулбуураас нь барьсан
Тавин сайн хөвгүүдийг
Ииш тийш нь ховх татаад
Дөчин есөн сарын газарт
Давхихыг тэмүүлэв.

Булингарын Догшин хар Саналдаа
Хүнд гарч Савар нь босож
Наян нэгэн алд балтаа
“Харь газарт хэрэгтэй зэр зэв” гэж өгөв.
Дараа нь арслангийн Араг Улаан Хонгор нь
Далан нэгэн алд билгийн шар болд илдээ
“Харь газарт хэрэгтэй болох зэр зэв,
Баруун ташаан дээрээ зүүж яв” гэж
Саналдаа босон өгөв.
Дараа нь баатар Гүзээн Гүмбэ нь
Бумбын орондоо алдаршсан
Болд хар чинжаал хутгаа
“Зүүн биедээ хавчуулж яв
Харь газарт хэрэгтэй” гэж хэлэн
Саналдаа босон өгөв.
Гунан шарын арьсаар голлож
Гунжин үнээний арьсаар хөвөөлж
Хорт могойн зоог дууриалгаж гөрсөн
Хотгор болдоор алгалсан
Товгор болдоор товчилсон
Залуу зандангаар ишилсэн

Залаа торгоор сагалдаргалсан
Айрстийн хар ташуурыг
Баруун гарын алганд
Шүүс гартал нь атгаад босов.
Мишил мөнгөн үүд рүү
Миймийн улаан гутлаар
Булц булц гишгээд гарав.
Шарын зургаан мянган
Арван хоёр баатар нь
“Явсан үйлээ номын ёсоор бүтээж
Алтан жолоогоо зөв эргүүлж
Алдарт ноён Жангарынхаа
Шар цоохор байшингийн
Хаш мөнгөн үүдэнд ирж буух болтугай!” гэж
Сайн үгээ хэлж
Сайхан ерөөлөө тавив.
Хаш мөнгөн үүдийг
Хангинуулж татаад
Таван мянган хонхы нь жингэнүүлж гараад
Буурал халzan хүлгийнхээ
Бугуйл мөнгөн цулбуурыг эвхэж аваад
Миймийн улаан гутлаа
Гинжир мөнгөн дерөөнд хүргэхийн үед
Олбог цагаан олонцог дээр
Оч мэт үсрээд мордов.
Одтой шар цоохор байшинг зөв эргээд
Олон сая албатаа тойроод
Оройн нарны зүг чиглээд давхив.

* * *

Алдарт ноён Жангар нь
Арван хоёр баатраа дагуулаад
Бумба далайн хөвөөнд буурилсан
Бумбын цагаан хуралдаа очиж мөргөл хийв.
Манай Санал хаана явна гэж
Манхан Цагаан уулын
Магнай дээр гарч
Магадалж сайн харав.
Бор уулын бэлд
Бонтгос гэж бараа харагдаад
Хар уулын хажууд
Хангис гэж чимээ гараад
Алга болоод өгөв.

* * *

Яг гурван сарын газарт
Яарч давхисаар хүрэв.
Өмнөөс нь нар сар болсон
Нарийхан сайхан хүүхэн
Ерөн есөн хүч төгссөн
Идээ ундаа аваад
“Ах минь, та
Аян замдаа
Аштай сайн морилж явна уу?
Ангаж өлсөж явна уу?” гэж

Аялгуут дуугаа дуулсаар ирэв.
Уужим сайхан цээжиндээ шинжлээд
Ухаан юугаа тунгаагаад
“Уул нутгийн минь захад
Угтаж ирсэн энэ гайхал
Угтаа лав шулам” гэж бодтол
Урдаас нь тулж ирээд
“Ухаант ноён ах минь!
Унд идээгий минь бууж зоогло” гэж мөргөв.
Бушуу явах хэрэгтэй би.
Бууж суух завгүй би.
Бузах замдаа идье” гэв.
“Буцалгасан цай хоолы минь
Бууж идэх завгүй болбол
Балгаж амсаад яв” гэж гуйв.
Санал баатар тэгээд
Сааталгүй шууд давхитал
“Унд идээг минь идэхгүй болбол
Улаан зүрхний чинь эхэнд
Урт хар хоншоороо шаагаад
Уушги зүрхий чинь сугална” гээд
Ухасхийгээд хойноос нь хөөв.
Цогтой Санал баатар
Цоохор олонцгийн доогуур
Дуутай долоон мянга давираад
Дуугүй найман мянга давираад зугтаав.
Өл буурал морь нь
Өмнө хоёр хөлөө

Өдрийн газарт тавиад
Хойд хоёр хөлөө
Хоногийн газарт тавиад
Эрүүгээрээ газар шүргэн давхиад
Өвчүүгээрээ өвс шүргэн давхиад орхив.
Хамрын хоёр нухнээс гарсан салхинд
Хагд өвс халиурч ярагдаад
Бужигнасан их тоос нь
Будан болж огторгуйг бүрхээд байв.
Нэг долоо хоног зугтав.
Нэхсэн шулам хөөж л явна.
Хоёр долоо хоног давхив.
Хойноос нь шулам хөөсөр л байна.
Гурван долоо хоног давхив.
Гутамшигт гайхал дагасаар л байна.
Долоон долоо
Дөчин есөн хоног давхиж явтал
Бузар хар шулмын
Буртагт хар хоншоор нь
Буурал халзан морины нь
Бумбын наян найман алд сүүлд нь
Бушуухан хүрмээр болж явна.
Буурал халзан морь нь
Буянт эзэндээ хэлэн явна:
“Булчин шөрмөс минь суларч байна.
Бушуулах хурд минь буурч байна.
Булзаарах аргаа өөрөө ол” гэв.



Халзан мориныхоо сайр дээр суугаад
Хайрт Хонгорынхоо өгсөн
Хатан болд илдийг
Хажуунаасаа суга татаад
Хар болд хоншоорых нь угаар
Хатгаж хуга цохив.
Мориныхоо жолоог эргүүлээд
Муухай биеий нь огтчоод хаяв.
Хүчит шулмыг дарж устаад
Хүлэг мориндоо мордоод
Яамай сайхан хурдаар нь
Яг турван сарын газарт давхив.
Өмнөөс нь бас
Нарийхан хонгор морьтой
Нар сар болсон сайхан хүүхэн
Алтан жолоогоо зөв эргүүлж ирээд

Авирах дөрөөнөөс нь
Адис аваад
“Ах ноён минь, мэндэлье, золгоё” гэв.
Ухаан юугаа тунгаагаад
“Эзэнгүй ээрэм цагаан талд явдаг
Энэ юун хүүхэн билээ?
Бас дахиад ямар
Балагтай юм дайралдав?
Үг хэлбэл хэл тастачах
Үзэж харвал нүд сохолчхох
Үйлтэй амьтан болуузай” гэж бодоод
Гурав дахиж дуудтал нь
Ганц ч дуу гарсангүй байв.
Эцэс сүүлд нь
Элгэн хар илдээ сугалаад
“Эрхэм хүүхэн! Ээл болбол ээлээ хэл
Дайтах болбол дайтахаа хэл!” гэв.
“Эндхийн өчүүхэн тивийн хааны хүүхэн
билээ би.
Ээл сэтгэлийн үндсээр ирлээ би.
Эрхэм ах Санал танд
Эвийн үг хэлэхээр ирлээ би.
Энхрий ахы минь,
Эрхт Заарын Заан тайж хааны нутгаас
Элч ирж барьж аваад
Эрүүдэх тамд хаяж орхисон юм.
Манай нутгийн мэргэн
Магад айлдагч Хүнхээн авгай хэлсэн билээ:

“Үүр цайх зүгт нутагтай
Үйзэн алдар хааны үлдэл
Үеийн өнчин Жангарын орноос
Үлэмж чадалтай нэг элч ирж
Үймүүлэгч Заан тайжийг дарах юм гэнэ билээ.
Үвтэгш тэр элчтэй заавал уулзаж
Үнэн үгээ айлтгаж
Үйл явдалдаа туслуул.
Эр хүнээр угтуулбал
Элч ууртай тул алж магадгүй.
Энхрий дагинаар угтуулж
Эв санаагаа илэрхийлж
Эзэн хааны өргөөнд залж
Элч морь хоёулыг амрааж
Идээ, ундаар хүндлээд мортуулагтун гэсэн юм” гэж
